

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-6
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-50
	1. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	8-15
	2. Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	15-35
	3. Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	36-37
	4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн мэдүүлсэн Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	37-50

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 20-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Байнгын хорооны дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 07 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Энх-Амгалан;

Чөлөөтэй: С.Бямбацогт;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг, Ж.Сүхбаатар;

Тасалсан: Ц.Сэргэлэн, Н.Учрал.

Нэг.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс үг хэлээгүй болно.

Л.Мөнхбаатар: Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Анхбаяр, Дотоодын цэргийн штабын дарга, бригадын генерал Р.Чингис, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа Л.Нямдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Б.Энхбаяр, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Дотоодын цэргийн штабын дарга, бригадын генерал Р.Чингис, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа Л.Нямдаваа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан, Ц.Сандаг-Очир, Д.Цогтбаатар, Ш.Раднаасэд, Х.Нямбаатар нар үг хэлэв.

Л.Мөнхбаатар: Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Н.Жамъянхүү, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, цагдаагийн хурандаа Ж.Буянбат, Шүүх шинжилгээний дүн бүртгэл мэдээллийн газрын захирал, цагдаагийн хурандаа Д.Мөнхбат, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний газрын

Чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Б.Эрдэнэ-Очир, Шүүх шинжилгээний газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч А.Амгаланболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан танилцуулав.

Төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн мэдүүлсэн Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Н.Жамъянхүү, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, цагдаагийн хурандаа Ж.Буянбат, Шүүх шинжилгээний дүн бүртгэл мэдээллийн газрын захирал, цагдаагийн хурандаа Д.Мөнхбат, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний газрын Чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Б.Эрдэнэ-Очир, Шүүх шинжилгээний газрын Чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч А.Амгаланболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир, Д.Ганбат нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Н.Жамъянхүү, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, цагдаагийн хурандаа Ж.Буянбат нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 53 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 12 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Л.МӨНХБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР
/МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн амрыг эрье.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулъя. Л.Мөнхбаатар ирсэн, Ш.Адъяаа гишүүн ирсэн, Н.Алтанхуяг гишүүн ирсэн, Э.Бат-Амгалан гишүүн ирсэн, С.Бямбацогт гишүүн чөлөөтэй, Б.Дэлгэрсайхан гишүүн ирсэн, Х.Нямбаатар гишүүн ирсэн, Ш.Раднаасэд гишүүн ирсэн, Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн, Д.Цогтбаатар гишүүн ирсэн, Б.Энхбаяр гишүүн нар хүрэлцэн ирсэн байна. Б.Энх-Амгалан гишүүн орон нутагт ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудалыг Та бүхэнд танилцуулъя.

Өнөөдөр дөрвөн асуудал хэлэлцэнэ.

Нэг. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газар 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Хоёр. Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт болох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газар 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Гурав. Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газар 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдөр өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг.

Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд. Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан. Анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалтай оръё.

Нэг.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэж баримтын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулъя.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна.

Х.Нямбаатар: Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, хуваарьт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс тус яамнаас Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлүүлэхээр Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах өөрчлөлтүүдийг тусгалаа.

Нэг. Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн хууль тогтоомж санаачлах эрхийн хүрээ хязгаарыг Хууль тогтоомжийн тухай хуулиар нарийвчлан зохицуулах нь оновчтой гэж үзэн холбогдох өөрчлөлтийг хийв.

Тухайлбал, Засгийн газар санаачилгаар Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд тусгайлан заасан, эсхүл эрүү, иргэн, захиргаа, зөрчил, гамшгаас хамгаалах, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх, төсөв, татвар, нийгмийн даатгал, нийгмийн халамж, боловсролын салбарын харилцааг зохицуулсан анхдагч болон шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийг Засгийн газар, Монгол Улсын Ерөнхийлөгч нь Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудлаар, эдгээрээс бусад асуудлаар Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлахаар тус тус тусгав.

Түүнчлэн хууль санаачлагч Улсын Их Хурлын тогтоолыг санаачилж болохоор. Тухайлбал, Засгийн газар санаачлан боловсруулахаар Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд тусгайлан заасан асуудлаарх Улсын Их Хурлын

тогтоолыг Засгийн газар, мөн Улсын Их Хурлын тогтоолын төслийг дагаж хууль санаачлахгүй байх өөрчлөлтийг тусгав.

Хоёр. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд Засгийн газраас санаачлах хуулийн төслийг тусган төлүүлдэг бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлын гишүүнээс санаачлах хууль тогтоомжийн төсөлд хамаардаггүй тул уг үндсэн чиглэлийг Засгийн газар баталж, Улсын Их Хуралд танилцуулахаар өөрчлөх нь зүйтэй гэж үзлээ.

Өөрөөр хэлбэл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрх, хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарт багтаан хэдий ч хууль санаачлах эрхтэй гэж үзсэн болно.

Гурав. Олон улсын туршлагаас судлан үзээд хуулийн төслийн танилцуулгыг товч болон дэлгэрэнгүй хийхээр тусгаж, дэлгэрэнгүй танилцуулгад хуулийн төсөл болон дагаж гарах хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр өөрчлөлт оруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томъёо, ухагдахууны үүсэл, хуулийн төслөөр зохицуулж байгаа харилцаа, түүний зохицуулалтыг хэрхэн ойлгох талаарх мэдээллийг оруулахаар заалаа.

Ингэснээр хууль санаачлагч ямар агуулгаар холбогдох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан талаар хууль хэрэглэх явцад ойлгомжгүй нөхцөл байдал үүсвэл танилцуулгад дурдсан тайлбарыг эх сурвалж болгон ашиглаж болох зохицуулалтыг тусгасан.

Дөрөв. Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд заасан агуулга ижил боловч өөр бичилттэй, тухайн нэр томъёог дагаж өөрчлөх шаардлагатай тохиолдолд холбогдох бүх хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай болно.

Тухайлбал, Улсын Их Хурлаас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан тусгай зөвшөөрөл гэсэн нэр томъёог зөвшөөрөл гэсэн агуулгаар өөрчлөхтэй холбоотойгоор 70 гаруй хуульд өөрчлөлт оруулсан байна.

Иймд хууль тогтвортой байх үүднээс хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд заасан нэр томъёог ижил утгаар ойлгож хэрэгжүүлэх, хэрэглэх тайлбарыг хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалтад тусгаж болох зохицуулалтыг тусгав.

Тав. Одоогийн хууль тогтоомжоор Улсын Их Хурлаас баталсан хуулиудын албан бус орчуулгыг хийх талаар ямар нэгэн эрх зүйн зохицуулалт байхгүй бөгөөд хуулийн төсөлд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хуулийн албан бус орчуулгын сан бүрдүүлж, хувийг эрх зүйн мэдээллийн албан ёсны цахим хуудсанд байршуулахаар хуульчиллаа.

Түүнчлэн хууль санаачлагч худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр боловсруулсан хууль тогтоомжийн төсөл болон энэ хуульд заасны дагуу судалсан судалгааны тайланг 60 хоногоос доошгүй хугацаанд эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршуулж, санал авахаар боллоо.

Ингэснээр Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хооронд байгуулж, Улсын Их Хурлаас соёрхон баталсан Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын талаар ил тод байдлыг хангах тухай хэлэлцээрийн Худалдаа, хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийг англи хэл дээр хэвлэн нийтлэхээр заасан зохицуулалтын хэрэгжилтийг хангахын зэрэгцээ хуулийн албан бус орчуулгыг хийх нь бүхэлдээ судалгаа шинжилгээний болон эдийн засгийн ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчин төгөлдөр дагаж мөрдөхөөс өмнө Улсын Их Хурал баталсан хуулиудын англи хэлний албан бус орчуулгыг холбогдох байгууллагууд уг хуулийг дагаж мөрдөж эхэлснээс хойш 3 жилийн хугацаанд хариуцан гүйцэтгүүлэхээр дагаж мөрдөх журмын тухай хуульд хуулийн төслийг боловсрууллаа.

Зургаа. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Монгол Улсын Их Хурлаас батлах шаардлагатай хөгжлийн бодлогын баримт бичиг, тухайлбал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн төлөвлөгөө зэрэгт Хууль тогтоомжийн тухай хуульд заасан үнэлгээ, судалгааг хийх шаардлагагүй байхаар өөрчлөлтийг тусгав.

Долоо. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх аргачлалын давхардлыг арилгах, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрх зүйн үндсийг хуульчлах өөрчлөлтүүдийг тусгалаа.

Хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгнө үү.

Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Х.Нямбаатар сайдад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах нар оролцож байна.

Төслийн үзэл баримттай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд байна уу? Нэрээ өгөөрэй. Б.Энхбаяр гишүүнээр тасаллаа. Б.Энхбаяр гишүүн асуултаа асууя.

Б.Энхбаяр: Хууль тогтоомжийн хуулийг хэлэлцэхийг дэмжиж байгаа.

Хууль тогтоох ажил дээр хууль дээдлэгдэж байж, тэр дотроо иргэд, олон нийтэд аливаа хуулийн төслийн талаар тэдний оролцоог аягүй сайн хангах асуудал. Бид улам сайжруулж л яваа. Тэгэхдээ дахиад сайжруулах шаардлагын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдаас оруулж ирж, тодорхой санал танилцуулж байна.

Тэгээд миний хувьд нэг л асуулт байна. Сүүлийн үед өмнө ч нэг их анзаардаггүй л байсан юм байна. Гишүүн болоод анзаараад байгаа юм. Энэ Байнгын хороод янз бүрийн хуулийг хэлэлцэж байх явцад нэг байгууллага байгуулаад байгаа юм.

Одоо жишээлбэл төсөв дагуулаад бид сая агентлаг байгуулж байх жишээтэй. Тэр нь болохоор Засгийн газар санаачлаагүй. Тухайн Байнгын хороо өөрөө шууд...

Л.Мөнхбаатар: Б.Энхбаяр гишүүн ээ. Таны яриа протоколд үлдэж байгаа. Бичлэгт үлдэж байгаа. Таны микрофон царгиад байна. Та цаад талдаа сууж байгаад ярьчихъя. Тэгэхгүй бол энэ нөгөө бичлэгийн шаардлага хангахгүй болчих байх.

Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Хууль тогтоомжийн хуулийг хэлэлцэхийг. Энэ чинь одоо бас л царгиад байна уу, үгүй юу. Ер нь цахилгаанжихаад байна уу, би. Аан. Хүндээ байна уу.

Их товчхон асуучихъя. Ганцхан асуулт. Одоо энэ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний асуудал энэ хуулийн төслийн үзэл баримтлалын 8 дээр орж ирээд байна л даа. Энэ Их Хурал, Байнгын хороод энэ Засгийн газар өргөн бариагүй байхад бүтэц, бүрэлдэхүүнтэй холбоотой асуудал хөндөөд, агентлаг байгуулаад сүүлийн үед яваад байна. Сая төсөв дээр тэгсэн шүү дээ. Засгийн газраас одоо жишээлбэл агентлаг байгуулах юм өргөн баригдаагүй байхад Их Хурал дээр Төсвийн байнгын хороо санал гаргаад л агентлаг байгуулчхаж байгаа байхгүй юу. Ядаж энэ Төрийн байгуулалтын байнгын хороогоор ордоггүй.

Тэгэхээр энэ дээр ер нь энэ хууль тогтоомжийн хуулиар бас бодож болгоож байгаа юм байгаа юм болов уу? Уг нь энэ чинь Ерөнхий сайдын Үндсэн хуульд заачихсан бүрэн эрхийн асуудал байгаа.

Тэгэнгүүт сайд нар нь Ерөнхий сайд дээрээ яриагүй асуудлыг Их Хурал дээр орж ирж Их Хурлын гишүүдийг лоббидож байгаад өөрийгөө харьяанд ингээд байгууллага байгуулдаг. Агентлаг байгуулдаг. Зарчим бол би энэ болохгүй гэж бодож байгаа. Байгуулах асуудлыг заавал Ерөнхий сайдтай ярьж, Ерөнхий сайд өөрөө оруулдаг байх ёстой байхгүй юу. Энэ дээр ямар бодол саналтай байгаа юм бол гэсэн ийм асуулт байна.

Л.Мөнхбаатар: Б.Энхбаяр гишүүний асуултад хуулийн төсөл санаачлагч Х.Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Б.Энхбаяр гишүүний асуултад би хариулъя.

Ер нь бид Байнгын үйл ажиллагаатай парламент бий болоод парламент өөрөөсөө гарч байгаа шийдвэрийн төслийг хүлээж авч санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх, хэлэлцэх журмыг бий болгох гээд сүүлийн бараг 30 гаруй жил явж байгаа. Хууль тогтоомжийн хууль үйлчилж эхлээд үндсэндээ 6 жил гаруй болж байна. 2016 оны сүүлээс хэрэгжиж эхэлсэн. Өмнөх парламент баталсан.

Энэ хооронд бид хэд хэдэн удаа өөрчлөлтүүд орсон. Үүнээс өмнө Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг боловсруулах, санаачлах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль гэсэн нэг нэртэй явж үзсэн.

Сая 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтөөр ер нь энэ хүрээ хязгаар Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчийн эрх мэдлийн хүрээ хязгаарыг тодорхой болгох ийм өөрчлөлтүүд 2019 онд орсон.

Тэгээд энэ хүрээндээ бид цаашид боловсронгуй болгохоор энэ хуулийн төслийг оруулж ирсэн.

Таны гаргаж байгаа санал дээр манай Д.Цолмон нэг нэмж, Х.Эрдэм-Ундрах хоёр хэлэх байх.

Ер нь бид ийм хэлэлцүүлгийн шатанд гуя дагуулж хүзүү гэдэг энэ зарчмыг л илүү их хязгаарлах шаардлагатай байгаа. Ингэхийн тулд дэгийн тухай хууль дээр бид бас эргэж харах шаардлагууд байгаа юм.

Б.Энхбаяр гишүүний хэлж байгаа дээр бид урьд нь маш том бүдүүлэг алдаанууд гаргаж байсан. Би хүртэл өөрөө гаргалцаж явсан хүмүүсийн нэг нь.

Тухайлах юм бол Улсын Их Хурлын даргын эрх хэмжээтэй холбоотой асуудлаар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх хэмжээтэй холбоотой асуудлаар, жишээлбэл Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр Улсын Их Хурлын гишүүд хамтдаа хууль санаачлаад оруулж ирж байсан ийм тохиолдол бол бий.

Тэгэхээр бид энэ алдаануудаа гаргахгүйн тулд хэн ямар хууль санаачлах вэ гэдэг хүрээ хязгаарыг үүгээрээ ингээд тогтоож өгье гэж байгаа юм. Жишээлбэл, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд. Б.Энхбаяр гишүүн сайн мэдэж байгаа шүү дээ. Бид хэд өөрчлөлт оруулаад л Ерөнхийлөгчийн санаачилсан төслөөр өөрчлөлт оруулаад л явчаж байсан.

Угтаа бол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг гэдэг бол бид хэд хоорондоо ярилцаж, ямар дэгээр явах вэ гэдгээ Их Хурал, Их Хурлын гишүүд санаачлах ийм л харилцаа. Гэтэл 2019 онд тухайн үеийн улс төрийн нөхцөл байдалтай холбоотойгоор Монгол Улсын Ерөнхийлөгч хуулийн төсөл санаачлаад л шууд дэгийн харилцааг зохицуулаад, түүнийг нь Их Хурал дэмжээд явчаж байсан ийм тохиолдлууд бий.

Тэгэхээр ийм алдаануудаа хэдүүлээ хумих зорилгоор гаргаж ирж байгаа юм.

Сая Төсвийн тухай хууль дээр нэг ийм асуудал гарсан. Монгол Улсын Төсвийн тухай хуулийг дагуулаад шинээр агентлаг байгуулаад, агентлаг татан буулгаад агентлаг байгуулаад явчихсан.

Тэгэхээр одоо үүнийг цаашид гаргахгүй байхын тулд бид Хууль тогтоомжийн тухай хуулийн энэ төслийг хэлэлцэх үедээ дэгийн тухай хуультай холбоотой асуудлыг эргэж харах асуудлыг одоо ажлын хэсэг гараад хэдүүлээ бүр нухацтай яримаар байна.

Хоёрдугаарт, бид нэг зүйлийг эргэж бүр аягүй тодорхой анхаармаар байгаа юм. Энэ юу вэ гэхээр дэгийн тухай хууль дээр эрх зүйн хийдэл үүсэхээс урьдчилан сэргийлээд хууль хэлэлцүүлгийн явцад хууль хоорондын зөрчил үүсвэл дэг дээр ямархуу ... гаргах вэ гэдгээ бас яримаар байна. Тэгэхгүй болохоор одоогийн сүүлд оруулсан дэгийн тухай хуулиар хийх хатуу болгочихсон. Тэгээд зөрчилтэй асуудлаар хуулийн хэлэлцүүлгийн шатанд хууль хэлэлцээд явбал цаашаа асуудал яах вэ гэдэг маань тодорхойгүй энэ тэр ийм харилцаанууд байна.

Тэгэхээр Д.Цолмон Б.Энхбаяр гишүүний саяын хэлж байгаа дээр ингээд гуя дагуулж хүзүү явбал яах вэ. Үүнийг яаж хязгаарлах вэ гэдгээ хэлээд.

Л.Мөнхбаатар: Д.Цолмон дарга хариулъя.

Д.Цолмон: Б.Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Энэ Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2.8 дээр заасан Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг зөвхөн Монгол Улсын Ерөнхий сайд тодорхойлж батлахаар орж ирсэн байгаа.

Өөрөөр хэлбэл хууль Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлд хуулийн хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг батлах гэдэг ийм зохицуулалтыг нарийвчлан зохицуулсан. Үүн дээр яг энэ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг зөвхөн Монгол Улсын Ерөнхий сайд тодорхойлж батлахаар оруулж ирсэн учраас Засгийн газраас өргөн бариагүй хуулийн төсөл дээр Байнгын хороодын түвшинд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах хуулийн төслийг батлах боломжгүй болж байгаа юм гэж ойлгож байгаа юм.

Л.Мөнхбаатар: Б.Энхбаяр гишүүн тодруулж асууя.

Б.Энхбаяр: Яах вэ, нэгэнт парламентын хямралд ороод парламент дахь улс төрийн намууд бас нэг тийм талцал үүсээд, улс төр гацаад байж болохгүй гэдэг талаасаа төрийн тэргүүн тэр түгжээг батлах ёстой шүү дээ.

Тэр утгаараа Ерөнхийлөгчийн тэр эрхийг хязгаарлах дээр жоохон бодмоор л юм шиг байна лээ. Юу ч гарч магадгүй. Амьдрал баялаг учраас.

Ер нь манай Улсын Их Хурал чинь янз янзын хуулиудтай. Босгуудаар янз янзаар уг нь тавьдаг л баймаар юм шиг санагдаад байгаа юм. Ялангуяа энэ Төсвийн тогтвортой байдлын хууль байна, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хууль байна, янз бүрийн томилгоонууд байна.

Яг Үндсэн хуулийг дагасан, одоо жишээлбэл Иргэний хууль ч гэдэг юм уу, Эрүүгийн хууль ч гэдэг юм уу, Газрын хууль ч гэдэг юм уу ийм суурь хуулиудыг.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Х.Нямбаатар сайд хариулъя. Б.Энхбаяр гишүүний асуултад.

Х.Нямбаатар: Тийм. Б.Энхбаяр гишүүн их чухал асуудал хөндөж байгаа юм.

Одоо Д.Цогтбаатар сайд ч мэдэж байгаа. Ер нь НҮБ-ын шийдвэр гарахдаа 100 хувь зөвшилцөл дунд шийдвэр гарах л ийм зарчим барьдаг юм билээ. Өөрөөр хэлбэл олонхоороо асуудлыг шийд. Төрд шийдэхээсээ илүүтэй зөвшилцөл дунд асуудал шийдэгддэг энэ зарчим руу бид цаашид нийгмийн томоохон суурь харилцааг зохицуулж байгаа хуулиудыг баталдаг ийм босго руу явмаар байгаа юм.

Би тэгээд өнөөдөр энэ Хууль зүйн байнгын хорооны хуралдаан дээр бас нэг зүйлийг хэлье гэж бодож байгаа юм. Энэ юу вэ гэхээр энэ оны төгсгөл болж байна. Энэ он гараад Хууль зүйн байнгын хорооны гишүүдэд Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр хоёр, гурван танилцуулга хийх хүсэлтэй байгаа. Тэр нь юу вэ гэвэл нэгдүгээрт энэ шүүх байгуулах хуулийнхаа урьдчилсан танилцуулгыг бид Та бүхэнд танилцуулж, нэг хэлэлцүүлэг явуулмаар байна.

Хоёрдугаарт, Үндэсний мөрдөх албаны тогтолцоо хийх чиглэлээр бас танилцуулга хиймээр байна.

Энэ дээрээ дандаа босготой.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд үг хэлээгүй. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Уг санал хуралдаанд оролцсон гишүүдийн 70.0 хувиар дэмжигдлээ.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? Э.Бат-Амгалан гишүүн танилцуулъя.

Дараагийнхаа асуудалд оръё.

Хоёр.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулъя.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна.

Х.Нямбаатар сайд танилцуулга аа хийе.

Х.Нямбаатар: Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт Монгол Улсын төрийн цэргийн байгууллагын тогтолцоонд тайван цагт Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ гэж, мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалтад цэргийн байгууллага нь Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, ард иргэдийн аюулгүй байдлыг цэргийн хүчээр хангах чиг үүрэгтэй, эрх зүйн нийтлэг хэм хэмжээгээр үйл ажиллагаа нь зохицуулагдаж, цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэдэг төрийн байгууллагыг ойлгохоор тус тус заажээ.

Дотоодын цэргийн тухай хуулиар дотоодын цэргийн чиг үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахаар заасан бөгөөд алба хаагчдын үүрэг гүйцэтгэх нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулахаар улсын онц чухал болон бусад объектын хамгаалалттай холбоотой эрх зүйн орчныг боловсруулах, боловсронгуй болгохоор зорилгоор Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсрууллаа.

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан төрийн цэргийн байгууллагууд нь цэргийн эрх зүйн хэм хэмжээ, цэргийн нийтлэг дүрмүүд, цэргийн цол, цэргийн алба хаагчийн бие бялдрын стандарт, энхийг дэмжих ажиллагаанд оролцох байдлаараа нэгдмэл байна гэж Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтад заасан “мэргэшсэн, тогтвортой байх” гэж Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад заасан албаны үүргээ гүйцэтгэх үедээ цэргийн дүрэмт хувцас, техник, материал хэрэгсэл, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдах гэж заасан зохицуулалтууд хангагдах юм.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтуудыг шинээр тусгасан.

Нэг. Дотоодын цэргийн байгууллага нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн цэргийн байгууллага мөн гэж тодорхойлон, төрөлжсөн болон дэмжлэг үзүүлэх, энхийг дэмжих, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох нэгжтэй байхаар зохицуулсан.

Хоёр. Дотоодын цэргийн штабыг дотоодын цэргийг удирдах, мэргэжлийн төв байгууллага болон штабын даргын албан тушаалд тавигдах шаардлагыг хуулийн төсөлд цагдаа болон дотоодын цэргийн аль нэг байгууллагад, эсхүл тухайн хоёр байгууллагад нийт 18-аас доошгүй жил ажилласан байхаар тусгаж, дотоодын цэргийн командлагчийн эзгүйд тодорхой эрхийг штабын дарга хэрэгжүүлэхээр тусгасан.

Гурав. Дотоодын цэргийн алба хаагчдын ажил үүргээ гүйцэтгэх нөхцөлийг сайжруулах зорилгоор Цагдаагийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн

59.1.4 дэх заалтад хот суурин дотор такси, үйлчилгээнээс бусад нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих гэж, 87 дугаар зүйлийн 87.3 дахь хэсэгт заасан цагдаагийн алба хаагч шилжин ажиллах болсноос шалтгаалан эхнэр, нөхөр нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнийг тэргүүн ээлжинд ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа цалингийн доод хэмжээгээр тооцож улсаас олгоно гэж 89 дүгээр зүйлийн 89.2 дахь хэсэгт аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа цагдаагийн албан хаагчид 30 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг 5 жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална гэж заасан нийгмийн баталгааг дотоодын цэргийн албан хаагчид нэгэн адил эдлүүлэх зохицуулалтыг тусгалаа.

Дөрөв. Дотоодын цэргийн алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэж байх үед дотоодын цэргийн командлагчийн зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглох, хараат бус байдлаар албан үүргээ гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлж, бусад төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчийн нэгэн адил алба хаасан хугацааг тооцохдоо ажилласан нэг жилийг нэг жил гурван сараар тооцох зохицуулалтыг тусгалаа.

Тав. Улсын онц чухал объектод үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт хүч, хэрэгсэл дайчлах, объектын хамгаалалтын найдвартай, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд нь шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник технологи, инженер техникийн хэрэгслийг нэвтрүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалуулагч байгууллагын нэмэлт санхүүжилтийг авч ашиглах талаар зохицуулалтыг нэмж тусгалаа.

Зургаа. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан шаардлагатай тохиолдолд улсын онц чухал объектоос бусад объектыг дотоодын цэргийн хамгаалалтад авч, аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгалаа.

Долоо. Улсын онц чухал объектын хамгаалалтад гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалттай байгаа объектын ойр орчимд илэрсэн сэжиг бүхий хүн, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх бичиг баримтыг шалгахад баримтлах Цагдаагийн албаны тухай хуульд заасан үйл ажиллагааны нийтлэг шаардлагыг нэмж тусган, гаргасан зөрчлийг шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд мөрдөх журам, зарчмыг нэмж тусган шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагад шилжүүлэх зохицуулалтыг бий болгосон болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгнө үү.

Анхаарлаа хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Х.Нямбаатар сайдад баярлалаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Анхбаяр, Дотоодын цэргийн штабын дарга, бригадын генерал Р.Чингис, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа Л.Нямдаваа нар оролцож байна.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд байна уу? Ц.Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Ш.Адъяаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адъяаа: Хуулийн төслийг дэмжиж байна.

Дотоодын цэргийн байгууллага ер нь цагдаагийн харьяанд олон жил явж ирсэн.

Тэгэхээр энэ асуудлыг хууль эрх зүйн хүрээнд шинэчилж, өөрчилж, өнөөгийн цаг үетэй холбогдуулж зайлшгүй шаардлага гарах ёстой гэж бодож байгаа. Нэн ялангуяа хөрөнгө санхүүгийн асуудал, түүнчлэн боловсон хүчний бодлогын тухайд ийм хоёрдмол ойлголттой явж байсан.

Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа, түүний дотор энэ бие дааж ажиллах дотоодын цэргийн бие бүрэлдэхүүний тэр ахуй хангамж, ажилласан жил, тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой зохицуулалтыг зайлшгүй хийх ёстой.

Энд нэг эргэлзээтэй асуудал байна. Өнөөдөр чинь нэг халдашгүй асуудал гээд л одоо Их Хурал руу хүртэл дайраад л, тэгээд л энд нэг халдашгүй юмыг чинь олон газар дээр ингээд яваад байгаа юм.

Тэгэхээр дотоодын цэргийн командлагч буюу Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвшөөрөлгүйгээр дотоодын цэргийн бие бүрэлдэхүүнтэй байгаа албан хаагчдыг албадан саатуулах, байцаах гэдэг юмыг өнөөдөр ярьж ингэж хуулиар тогтоох нь зөв үү, буруу юу?

Өнөөдөр энэ асуудал дээр би тийм шүүмжлэлтэй хандаж байна. Яагаад гэвэл энэ чинь халдашгүй гэдэг байдал, одоо тэгээд л олон газар байгаа шүү дээ. Энэ чинь одоо энэ Үндсэн хуулийн цэц, Их Хурал, тэгээд шүүх, прокурор, тэгээд одоо ингээд нийгэмд ийм асуудал яригдаад явагдаж байгаа цаг үед энэ асуудлыг ийм байдлаар оруулах нь бас учир дутагдалтай байна гэдэг ийм саналтай байна.

Ямар бодлогын үүднээс энэ заалтыг оруулж ирсэн бэ гэдгийг хууль санаачлагчаас тодруулах бодолтой байна.

Л.Мөнхбаатар: Хэн хариулах вэ? Д.Цолмон дарга эхэлж хариулаад. Хэдэн номер вэ? 5 номер. Дараа нь Р.Чингис дарга нэмж тодруулж хариулъя.

Д.Цолмон: Ш.Адъяшаа гишүүний асуултад хариулъя.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр дотоодын цэргийн албан хаагчийн эрх дээр тодорхой нэг эрхийг нэмэгдүүлж орж ирсэн.

Энэ бол хамгаалалтад байгаа объектын ойр орчимд илэрсэн сэжиг бүхий хүн, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, бичиг баримтыг шалгах, зөрчил гаргасан хүнийг 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулах, илэрсэн зөрчлийг цагдаагийн байгууллагад шалгуулах, шалгуулахаар шилжүүлэх гэсэн эрхийг цагдаагийн алба хаагчийн нэгэн адил нэмэгдүүлж орж ирсэн.

Таны ярьж байгаатай холбогдуулан дотоодын цэргийн командлагчийн зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно гэсэн заалтыг бас мөн адил 36.8-д нэмэлтээр оруулж өгсөн байгаа.

Нэмэлтээр Л.Нямдаваа дарга.

Л.Мөнхбаатар: Р.Чингис генерал хариулъя. 3 номерын микрофон өгье.

Р.Чингис: Ш.Адъяшаа гишүүний асуултад миний бие хариулъя.

Дотоодын цэргийн энэ хуулиар улсын онц чухал объект гэж нэр томъёолол байдаг. Тэрийг бол Монгол Улсын Засгийн газраас тогтоосон тийм эрх хэмжээний асуудал байдаг юм. Тэр нь юу вэ гэхээр дотоодын цэрэг нь улс орны нийгэм, эдийн засаг, стратегийн онцгой ач холбогдол бүхий байгууллага, үйлдвэр, барилга байгууламжийг хуулиар хамгаалдаг тийм төрийн цэргийн хууль сахиулах байгууллага юм.

Энэ дээр тодорхой дэглэм байдаг. Дээрээс нь аюулгүй байдлын асуудал яригддаг. Алба хаагч нар энэ цэргийн албаны дүрмийн дагуу бас галт зэвсэг хэрэглэдэг. Зөвхөн энэ байгууллагын аюулгүй байдлыг хангах үүднээс

дараагийн ээлжийн хүмүүсийг шуурхай хүргэх асуудлыг нь гарахын тулд заавал дотоодын цэргийн командлагч мэдэгдэж байж явуулдаг юм.

Мэдэгдэхгүйгээр шууд нэгжлэг, үзлэг, шалгалт зөвхөн ажлын үүргээ гүйцэтгэж байгаа үе шүү. Энэ бол халдашгүй байдлын асуудал биш. Энэ бол албан үүргээ шуурхай, тасралтгүй явуулах зарчим, асуудал байгаа.

Түүн дээр би гишүүдэд нэг юм хэлэхэд энэ бол дахиж хэлэхэд халшгүй асуудал биш. Энэ бол улсын онц чухал объектыг улс орны аюулгүй байдлыг хангах үүднээс хамгаалж байгаа байдлаас ямар нэгэн эрсдэл үүсгэхгүйгээр дотоодын цэргийн командлагч мэдэгдэж, дотоодын цэргийн командлагчийн зөвшөөрснөөр яаралтай шуурхай дараагийн ажлуудыг нь явуулах, тасралтгүй ажлыг нь хангуулах л асуудал байгаа.

Түүнээс мөрдөн шалгах асуудалд саад учруулах, ямар нэгэн байдлаар эсэргүүцэл үзүүлэх, хэрэг шалгах асуудалд саад учруулах тийм асуудал байхгүй. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Б.Энхбаяр гишүүн асуултаа асууя. Байж байгаарай. Ш.Адъяаа гишүүн нь тодруулж асууя. Нэмэлт 1 минут.

Ш.Адъяаа: Р.Чингис дарга аа, би сайн ойлгож байгаа. Тэгэхдээ тэр улсын онц чухал объектод албан үүрэг гүйцэтгэхтэй холбоотой асуудал дээр ерөөсөө яриагүй.

Ер нь өнөөдөр хүнийг албадан саатуулах, нэгжих, баривчлах асуудал бол мөрдөн байцаах байгууллагын хэмжээнд хоёр, гуравхан байгууллагын хэмжээнд л явагдана шүү дээ. Үүнтэй холбоотой асуудал нийгэмд ийм байдал үүсэх вий дээ гэдэг үүднээс ярьсан юм.

Түүнээс биш танай байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой, энэ онц чухал объектод холбоотой асуудалтай би ийм юм яриагүй ээ. Энэ чинь өнөөдөр нийгэм бид нар луу ямар асуудал яриад байна гэхээр энэ халдашгүй байдалтай холбоотой асуудлыг л яриад байгаа юм. Ийм байдлаар өнөөдөр харагдах вий. Тэгээд цаашдаа ер нь халдашгүй байдал гэдэг юм чинь өнөөдөр цагдаа, тэгээд л бүр үндэсний аудит.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ш.Адъяаа гишүүн үг хэллээ. Б.Энхбаяр гишүүн асуулт асууя.

Б.Энхбаяр: Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс хэдэн асуулт байна.

Эхний асуулт. Төслийн 7.3-т дотоодын цэргийн террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох мэргэжлийн нэгжтэй байна гэж байгаа.

Тэгэхээр дотоодын цэрэг гэдэг бол цэрэг байгаа. Тэгэхээр энэ бол нөгөө тусгай салааг ярьж байх шиг байна л даа. Террорист үйлдлийн эсрэг сөрөг тусгай ажиллагаанд оролцох гэхээр. Энэ нөгөө хугацаат цэргүүдээсээ бүрдүүлсэн ийм салаа гаргах гээд байна уу, яах гээд байна вэ?

Тэгэхээр цэргийн хууль үйлчлэх гээд байна уу? Энэ салаан дээр цагдаагийн хууль үйлчлэх гээд байна уу. Аль хууль нь үйлчлэх юм? Энэ тусгай салаанд гэсэн ийм асуулт байна.

Хоёрт нь, Дотоодын цэргийн штабын дарга нь цагдаа, дотоодын цэргийн байгууллагад 18-аас доошгүй жил ажилласан байх шаардлага тавьж байгаа юм байна. Энэ нөгөө яг шүүхийн шинжилгээ шиг л орж ирж байна. Бусад хуульд заасан шаардлагаас ажилласан жилийн хувьд их өндөр ийм шаардлага орж ирж байна. Энэ дээр ямар байр суурьтай байна вэ гэсэн асуулт байна.

Дараа нь 9.4 дээр штабын дарга нь дотоодын цэргийн командлагчийг түр эзгүйд орлоно гэсэн ийм заалт орж ирж байна.

Тэгэхээр штабын дарга нь ер нь командлагчаа орлодог юм уу? Хил дээр яадаг юм? Зэвсэгт хүчин дээр яадаг юм? Би ийм ерөөсөө анх удаа уншиж байгаа болохоор гайхаад л асууж байгаа шүү.

Штабын дарга бол одоо энэ командлагчийг оролдог гэж би ерөөсөө мэдэхгүй юм байна. Энэ яагаад ийм заалт орж ирсэн юм бол гэсэн асуулт байна.

Дараагийн асуулт нь, дотоодын цэрэг, хот суурингийн дотор таксинаас бусад нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих эрхтэй болох юм байна. Энэ яагаад ийм шаардлага оруулж ирсэн юм бэ?

Бид чинь бүх төрийн албан хаагчдаа ингээд нийтийн тээвэрээ үнэгүй зорчуулдаг болгох юм уу?

Дараагийн асуулт. Энэ 36.7. Дотоодын цэргийн албан хаагчийг гэмт хэрэг үйлдэж байхад нь эсвэл гэмт хэргийн газарт үйлдлийг нотлох баримтаар баривчилснаас бусад тохиолдолд дотоодын цэргийн командлагчийн зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно гэсэн. Энэ нөгөө зөвхөн шүүгч, цэцийн дарга нар дээр яригддаг өндөр халдашгүй эрх ороод ирсэн байна.

Энэ дотоодын цэргийн албан хаагч дээр ийм халдашгүй эрх яагаад ийм юм үйлчилж байгаа билээ? Энэ чинь зөвхөн шүүгч дээр үйлчилдэг, Ерөнхий прокурор дээр үйлчилдэг, Ерөнхийлөгч дээр үйлчилдэг, Цэцийн гишүүд дээр үйлчилдэг ийм халдашгүй байдлын бүрэн эрх орж ирсэн байна. Тэгээд энэ зарчмыг би дэмжихгүй байна.

Тэгээд энэ яагаад ийм юу орж ирсэн юм бэ гэсэн асуулт байна.

Л.Мөнхбаатар: Б.Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Х.Нямбаатар сайд хариулна.

Х.Нямбаатар: Сөрөг тусгай ажиллагааны нэгжийн талаар манайхан нэмж хариулах байх. Х.Нямдаваа ер нь миний араас бас нэмээд хариулах байх.

Энэ бол нэгдүгээрт хугацаат цэргийн тухай асуудал яригдахгүй. Энэ энхийг сахиулах ажиллагаанд цагдаа, дотоодын цэргийн байгууллагууд оролцох эрх зүйн үндэс бүрдээд саяхан Засгийн газрын тогтоол гарсан. Энхийг сахиулах ажиллагаанд энхийг сахиулах цагдаагийн чиг үүргээр Монгол Улсын цагдаа, дотоодын цэргийн байгууллагын нэгж, олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцох энэ бэлтгэлээ хангах үүднээс Дотоодын цэргийн тухай хуульд эрх зүйн байдлыг нь тодорхой болгож өгч байгаа гэдгийг хэлье.

Хоёрдугаарт, Б.Энхбаяр гишүүнийг Хууль зүй, дотоод хэргийн яамны дэд сайдаар ажиллаж байх үед дотоодын цэргийн байгууллагыг шинээр сэргээн байгуулах эрх зүйн үндэс бүрдсэн.

Тэгэхээр бид дотоодын цэргийн байгууллагыг бэхжүүлэхийн тулд тодорхой эрх зүйн орчныг нь бий болгох ажлууд шат дараатай хийгдэж байгаа. Шинээр дотоодын цэргийн нэгжүүдийг байгуулах ажлууд үе шаттай хийгдээд явж байгаа. Одоо энэ нүүрсний хулгайн гэх асуудал гарсантай холбогдуулаад өнгөрсөн жил бид дотоодын цэргийн 810 дугаар ангийг Таван толгой уурхайн орчинд байгуулсан.

Цаашид энэ төрийн өмчит компаниудын онц чухал объектуудын хамгаалалт дээр дотоодын цэргийг ажиллуулах нь илүү үр дүнтэй байх юм. Хувийн гэрээт хамгаалалтын албадууд дээр тодорхой алдаа эндэгдлүүд гарч байна. Зарим хувийн гэрээт харуул, хамгаалалтын албадын бараг 50-виас илүү хувь нь урьд нь ял шийтгэл эдэлж байсан хүмүүс энэ харуул хамгаалалтын үүргийг гүйцэтгэж байгаа нь өөрөө нөгөө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд эрсдэл үүсэж байна гэдэг ийм дүгнэлт гараад бид ийм ажлууд хийж байгаа.

Хоёрдугаарт, төв суурингийн..., Байнгын хорооны дарга миний минутыг нэмээд өгчихвөл сайн байгаа.

Төв суурин газруудын ундны усны хамгаалалтууд дээр бид бас ер нь дотоодын цэргийнхээ хамгаалалтуудыг ажиллуулъя. Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед цагдаад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэйгээр нөгөө функциональ чиг үүрэгтэйгээр ажилладаг зарчим руу шилжье гээд бид ийм бас нэг зарчим, бодлого гаргаад ажиллаж байгаа гэдгээ хэлье.

Өмнө нь хэд хэдэн суурин газрууд дээр асуудал үүссэн. Тухайлах юм бол нэг суурин газар цианит натрийг ундны усны газруудад хийх гэсэн оролдлогууд энэ тэр гарч байсныг манай бас Байнгын хорооны гишүүд сонсож байсан байх.

18-аас доошгүй жил гэдэг дээр нэг ийм юм байгаа юм. Б.Энхбаяр дарга та бид хоёр бол нас ойролцоо. Та бид хоёрын ажилласан жил бол харьцангуй бага тоологддог.

Энэ цагдаа, дотоодын цэргийн байгууллага дээр ажилласан жил маш хурдан хугацаанд тоологдоод явдаг. Нэгдүгээрт, ажилласан жил дандаа үржиж явдаг. Хоёрдугаарт цэргийн сургуульд сурсан хугацаа нь өөрөө 4 жилээр тоологддог.

Саяхан бид Рэгжээбүүгийн Отгонжаргал генералыг энгийн салбарт шилжих гэж байгаатай холбоотойгоор ажилласан жилийг нь тоолоход одоо бидэнтэй л нас ойролцоо залуу шүү дээ. Тэгэхэд 29 жил цагдаа, дотоодын цэргийн байгууллагад ажилласан гээд тоологдож байгаа юм.

Тэгэхээр бид нөгөө мерит зарчим тоолохын тулд нэгдүгээрт энэ хүн тасгийн дарга болсон байх ёстой. Ахлахаар ажиллаад тасгийн дарга болсон байх ёстой.

Хоёрдугаарт, хэлтсийн даргаар ажиллаж байсан байх.

Гуравдугаарт, газрын даргаар ажиллаж байж дараагийнхаа юу руу очихоор энэ тоологдож байгаа хугацаа ерөөсөө 18 жил гээд ингэж тоологдоод байгаа шүү гэдгийг хэлье.

Командлагчийн эзгүйд штабын дарга шийдвэр гаргах шаардлагатай болно.

Тэгэхээр командлагчийг хэн орлох вэ гэхээр цагдаа дээр тэргүүн дэд дарга орлоно. Дотоодын цэрэг дээр тэргүүн дэд дарга орлох нь өөрөө чиг үүргийн хувьд уялдахгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл тэргүүн дэд дарга бол.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Х.Нямбаатар сайд гүйцээгээд хариулъя. Нэмж хариулъя.

Х.Нямбаатар: Жишээлбэл, Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга Ц.Ням-Очир генералын хувьд командлагчийг эзгүйд ямар асуудлаар орлох вэ гэхээр нэгдүгээрт цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн эрүү, мөрдөн, хэв журмынхаа чиглэлээр командлагчийн эзгүйд шийдвэр гаргах ёстой болж байгаа юм.

Дотоодын цэрэг рүү дотоодын цэргийн чиг үүргийг Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргад хуулиар харьяалуулаагүй учраас хуулиар

харьяалуулж байгаа чиг үүрэгтэй Дотоодын цэргийн штабын дарга нь одоо энэ чиг үүргийг олж явах нь илүү зохимжтой гэж үзсэн.

Гэхдээ та бүхэн үүнийг бас хэлэлцүүлгийн шатанд эргэж харж болох байх.

Цагдаагийн байгууллагын алба хаагч бол өнөөдөр нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчоод явж байгаа.

Тэгэхээр өнөөдөр хэдүүлээ нөгөө хотын түгжрэлийг бууруулъя гэдэг энэ чиг үүрэг дээр би бас л давхар уялдаад л явна. Дотоодын цэргийнхэн, цагдаагийн арван мянга, арван хэдэн мянган албан хаагчид бүгд нийтийн тээврээр зорчихгүй, тээврийн хэрэгслээрээ зорч гэвэл тэгээд л бас л хотын түгжрэлд нэг л асуудал үүснэ.

Энэ халдашгүй эрхийн асуудал дээр эргэж ярилцъя. Зүгээр энэ дээр Л.Нямдаваа нэг үндэслэл аргумент гаргаад хэлэлцүүлгийн явцад ийм байх ёстой. Өөрөөр хэлбэл хүч хэрэглэдэг ийм байгууллага өөрөө эргэж энэ асуудлыг ингэж зохицуулж явах ёстой л гэдэг яасан.

Эргээд хэдүүлээ хасчихаж болно. Энэ дээр би хууль санаачлагчийн хувьд энэ дээр нэг их ийм хатуу байр суурь эзлэхгүй. Зүгээр би өөрийн алба хаагчдын бас байр суурийг сонсьё гэж бодож байгаа. Л.Нямдаваа хурандаа руу микрофоноо шилжүүлье.

Л.Мөнхбаатар: Хурандаа Л.Нямдаваа асуултад хариулъя. 2 номерын микрофоныг өгье. Ажлын хэсгийн.

Л.Нямдаваа: Б.Энхбаяр гишүүний асуултад товч хариулъя. Цагдаагийн ерөнхий газар. Л.Нямдаваа.

7.3-т заасан террорист сөрөг тусгай ажиллагааны болон энхийг дэмжих ажиллагааны бүтэцтэй холбоотой эхний асуулт асуулаа. Энэ бол Үй олноор хөнөөх зэвсэг үл дэлгэрүүлэх болон терроризтой тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйл дээр терроризмтой тэмцэх сөрөг тусгай ажиллагаанд оролцох хүч хэрэгслэл гэдгийг дотоодын цэргийн анги, штаб гээд заагаад өгчихсөн байдаг.

Мөн Энхийг сахиулах үйл ажиллагааны тухай хууль дээр мөн адил энхийн юун дээр цэргийн багт нь дотоодын цэрэг оролцож явдаг. Тийм болохоор энэ дээр нь дотоодын цэргийн хүч хэрэгсэл оролцоно. Энэ дээр Энхийг сахиулах ажиллагааны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, дээрээс нь Үй олноор зэвсэг үл дэлгэрүүлэх болон терроризмтай тэмцэх тухай хуулийг баримталж ажиллана.

Хоёрдугаар асуудал дээр нь, дотоодын цэргийн штабын даргад яагаад 18 жил тавьсан бэ гэдэг. Түрүүн сайд тайлбарлачихлаа. 18 жилийнх нь үндсэндээ 4 жил нь бол яг нөгөө цэргийн мэргэжлийн сургууль төгсчихсэн байдаг. Сургууль

төгсөөд тухайн хүн 10 жилийн дараа гэхэд хошууч цолтой буюу ахлах офицерын зэрэглэлд очдог. Энэ байдлаар нь төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх гэдэг шалгуураар нь тавьж 18 жил байх нь зөв болов уу гэдэг байдлаар тавьсан.

Хэлэлцүүлгийн явцад энэ жилийн хугацаатай асуудлыг эргэж харах боломжтой гэж үзэж байна.

Дотоодын цэргийг түр орлон гүйцэтгэхийг түрүүн дарга ярьчихсан. Түрүүн нөгөө 9.4 дээр чинь болохоор цагдаагийн төв байгууллагын дарга бол дотоодын цэргийн командлагчийн үүргийг давхар хавсран гүйцэтгэдэг. Энэ утгаараа цагдаа талын орлогч нь тэргүүн дэд дарга. Дэд дарга нар нь тухайн чиг үүргээрээ харьяалан явдаг. Штабын дарга нь цэргийн мэргэжлийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцаж явдаг. Үүнтэй холбоотойгоор дотоодын цэргийн командлагч нь тодорхой бүрэн эрхээ дотоодын цэргийн штабынхаа даргад шилжүүлэх эрх зүйн акт гаргаж шилжүүлэх байдлаар ингэж зохицуулж явах нь зөв юм байна. Одоо бол яг үүнийг нь зохицуулсан нь тодорхой эрх зүйн акт байхгүй.

Л.Мөнхбаатар: Л.Нямдаваа хурандаа наадуул чинь Х.Нямбаатар сайд хариулчихсан шүү дээ. Наад гурван асуултанд чинь. Гол тодруулж асуугаад байгаа зүйл чинь халдашгүй байдлын асуудлыг л тодруулж асуугаад байгаа юм.

Л.Нямдаваа: Дотоодын цэргийн үндсэн чиг үүрэг нь болохоор улсын онц чухал объектын харуул хамгаалалтыг хариуцдаг. Энэ нь өөрөө юу гэсэн зохицуулалт байдаг вэ гэхээр улс орны нийгэм, эдийн засаг, стратегийн ач холбогдол бүхий ийм барилга байгууламж, тодорхой цэгийг бол хамгаалж байдаг.

Энэ цэг дээр үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчийг тодорхой хэрэг зөрчилд холбогдуулан шалгахгаар болбол ерөөсөө командлагчид нь мэдэгдээд тухайн объектоос нь чөлөөлөх гэдэг юм уу, ийм арга хэмжээг аваач ээ. Шууд мэдэгдэхгүй явснаас үүдээд тухайн объект эзэнгүйдэх асуудал үүснэ. Энэ байдлыг л харгалзаж энэ зохицуулалтыг оруулж ирсэн. Тийм тодотгож болно гэсэн үг.

Л.Мөнхбаатар: Үгүй, үгүй. Одоогийн томъёолол чинь ч гэсэн тийм байгаа биз дээ. Албан үүргээ гүйцэлдэж байгаа л гэсэн агуулга шүү дээ.

Б.Энхбаяр гишүүн тодруулж асууя?

Б.Энхбаяр: Тэгэхээр дотоодын цэргийн байгуулах гэж байгаа энэ терроризмын эсрэг сөрөг тусгай салаа байна шүү дээ. Тэр чинь тусгай салаа байгаа байхгүй юу. Энэ чинь одоо яг цэргийн хуулиар явах уу? Одоо мэдлээ, гүйцэтгээ гээд энэ чинь галт зэвсэг шууд хэрэглэнэ шүү дээ. Шууд устгана шүү дээ. Хүний амь насанд халдах. Одоо шууд терроризм үйлдэл, халдлага болоод.

Энэ чинь одоо цэргийн хуулиараа явж байна уу, цагдаагийн эрх хуулиараа яваад байна уу? Аль хуулиа барих вэ? Яг энэ салаа.

Яагаад гэхээр энэ чинь одоо жишээлбэл энэ салаа бол жишээлбэл нийтийн эмх замбараагүй байдлын үед татагдаж орох боломж бүрдэх гээд байна шүү дээ.

Тэгэхээр энэ аль хуулиараа явах вэ? Цэрэг, цагдаа хоёр чинь арай өөр байгаа шүү дээ. Шууд цэргийн хуулиар явна гэвэл энэ чинь бол нэлээн хүч чадалтай тийм салаа байгаад байна шүү дээ. Мэргэшсэн. Энгийн цэргээс ч бас ялгаатай.

Л.Мөнхбаатар: Б.Энхбаяр гишүүний асуултад хурандаа Л.Нямдаваа хариулъя. 2 номерын микрофон.

Л.Нямдаваа: Б.Энхбаяр гишүүний асуултад нэмж хариулъя.

Энэ нөгөө Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризтой тэмцэх тухай хуулийн зохицуулалтын дагуу явна. Энэ ажиллагааг Терроризтай тэмцэх зөвлөл буюу Тагнуулын ерөнхий газрын зөвлөлийн дэргэд энэ бие бүрэлдэхүүн орж ажиллана гэсэн үг. Энд ганцхан дотоодын цэрэг биш цагдаа, цагдаагийн төв байгууллага, түүний харьяа нэгж анги, байгууллагууд, тагнуул, тэгээд мэргэжлийн хяналт гээд ингээд тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд ажиллана.

Л.Мөнхбаатар: Ц.Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Би Дотоодын цэргийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг одоо зарчмын хувьд дэмжиж байна. Гэхдээ тодруулж асуух зүйлүүд байна.

Нийгмийн асуудал, баталгааг хангах тал дээр заалтууд орж ирж байгаа юм байна. Ерөнхийдөө цагдаагийн албан хаагчтай адилтгаж үзэж байгаа юм байна.

Ер нь 2023 оны улсын төсөв батлагдчихсан. Тэгэхээр энэ хууль батлагдаад хэрэгжээд эхлэхээр хэзээнээс хэрэгжиж эхлэх юм? Нэгд.

Хоёрт, мөнгөн дүнгээрээ тооцвол ирэх жилийн төсөвт орсон юм уу, ороогүй юм уу, туссан юм уу, тусаагүй юм уу? Мөнгөн дүнгээрээ хэдий хэмжээний төсөв дээр нэмэлт зардал бий болох юм? Нөгөө талаас дотоодын цэргийн албанд нийт хэдэн хүн ажиллаж байна? Улсын хэмжээнд хэдэн хүн ажиллаж байна, хэдэн хүний асуудал яригдах юм?

Цагдаагийн албан хаагч, дотоодын цэргийн албан хаагч хоёрын хоорондын цалингийн ялгаа, дундаж цалин ер нь хэдийг авч байна вэ?

Цагдаагийн албан хаагчид маань хэдэн төгрөгийн дундаж цалинтай байна? Дотоодын цэргийн албан хаагчид маань хэдэн төгрөгийн дундаж цалинтай байна аа? Үүнийг тодруулж өгөөч ээ.

Нөгөө талаар дотоодын цэргийн албан хаагчдыг цагдаагийн албан хаагчтай адилтгахаар аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа гэж байна. Тасралтгүй гэхээр одоо яг хэдэн жил ажилласан. Нэг жил ажиллаад энэ нэмэгдэл урамшуулалд хамрагдах бололцоотой юм уу? Доод тал нь 5 жил гэсэн ийм шалгуур юм байдаг юм уу? Үүнийг нэг хэлж өгөөч.

Нөгөө талаас бас л өмнөх хуулиуд дээр яригдаж байсантай адилхан хотын нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх гэсэн дүүргүүдийн цагдаагийн албан хаагчид, дотоодын цэргийн албан хаагчид энэ 5 жил тутмын 30 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулалд хамрагдах бололцоо боломж байхгүй юу. Хууль зүйн сайд аа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албан хаагчдын ажилчид бас хамрагдахгүй байгаа. Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба хаагчдын энэ алслагдсан нэмэгдэл Багануурын хорих ангийн албан хаагчид хохироод байгаа юм билээ. Х.Нямбаатар сайд аа.

Яагаад гэхээр Багануурын хорих ангид Багануураараа нэрлэгдээд ингээд хотын дүүрэгт байдаг гээд. Тэгвэл яг газар зүйн байршлаараа Төв аймгийн Баяндэлгэр сумын газар дээр байдаг юм билээ шүү. Тэгээд энэ нэмэгдэл урамшуулалдаа хамрагдаж чадахгүйгээр өдий хүртэл ингээд хохироод яваад байгаа.

Тэгэхээр би Хууль зүйн яамнаас нэг л зүйлийг асуух гэсэн юм. Энэ харьяа байгууллагуудынхаа нийгмийн асуудлыг ярихдаа энэ алслагдсан 3 дүүргийн албан хаагчдын нийгмийн асуудлыг хамтад нь ярьж өгөөч ээ. Яг л газар зүйн байршлаараа алслагдсан. Тэнд төрийн албан хаагчдыг тогтвортой ажиллуулах хэрэгцээ шаардлага байна уу гэвэл байна. Тэгээд дандаа ингээд хаягдаж явж ирсэн. Энэ дээр та бүхэн Хууль зүйн яам нэг онцгой анхаарал хандуулж өгөөч ээ л гэж хүсэх гээд байгаа юм. Энэ дээр тийм бололцоо боломж байна уу?

Л.Мөнхбаатар: Ц.Сандан-Очир гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 2 номерын микрофон. Хурандаа Л.Нямдаваа хариулъя.

Л.Нямдаваа: Дотоодын цэргийн алба хаагчдын тоо бол улсын нууцад хамаардаг болохоор тодорхой тоо танд хэлэх боломжгүй байна. Р.Чингис дарга танд тусгайлан танилцуулчих байх.

Хоёрдугаарт нь, ерөнхийдөө дотоодын цэрэгт ажиллаж байгаа хүмүүсийг оршин сууж байгаа газрынх нь чиглэлээр 4 чиглэлд оршин суудаг юм байна.

Ихэвчлэн 05 гэдэг юм уу, тэр ангийнхаа эргэн тойронд оршин суудаг. 4 чиглэлд нийтийн тээврийн хэрэгслээр зорчдог. Жилдээ ерөнхийдөө цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төсөв дээр 100 гаруй сая төгрөг төсөвлөдөг юм байна. Үүнийг нь зүгээр нийтийн тээвэр рүүгээ шилжүүлээд өгөөд объектын харуул хамгаалалтын ирж, очих зардлыг нь цагдаатай адилхан үнэгүй явуулчихъя гэж байгаа юм байна.

Хоёрдугаарт нь, тасралтгүй гэдэг нь аймгийн төвөөс бусад суманд 5 жилийн хугацаанд тасралтгүй ажилласан бол урамшуулал олгохоор. Одоогоор 2023 оны төсөвт тусгагдаагүй. Бид тооцоолохдоо ер нь 2023 онд 46 сая төгрөг, 2024 онд 61 сая төгрөг, 2025 онд 67 сая төгрөгийн төсөв шаардлагатай юм байна гэдэг урьдчилсан тооцоолол гарсан.

Энэ хууль батлагдсанаар одооноос эхэлж тоолоод 2027 оноос хэрэгжих боломжтой гэж харж байгаа.

Дараагийнх нь дотоодын цэргийн албан хаагч хэдэн төгрөгийн цалин авч байна гээд. Ахлагч бүрэлдэхүүн одоогоор 1 сая 200, 300 төгрөгийн цалин авч байгаа. Гар дээр.

Багануур нөгөө алслагдсан дүүргээ яах вэ гээд байгаа. Үүнийг хэлэлцүүлгийн явцад хууль санаачлагч маань хүлээж та бүхэн маань явал үүнийг зарчмын хувьд дэмжиж байгаа.

Аймгийн төвөөс бусад сум гэвэл тодорхой цөөхөн газар байгаа. Одоо юу гэдэг юм Баян-Өлгий аймгийн нэг чөлөөт бүс байгаа. Цагааннуурын чөлөөт бүс дээр хэдэн тодорхой тооны албан хаагч ажиллаж байгаа.

Тэгэхээр нэг их тийм төсөв дээр хүндрэл учраад илүү зардал шаардагдаад байхгүй ийм л асуудал байгаа.

Л.Мөнхбаатар: Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Д.Цогтбаатар, Ш.Раднаасэд гишүүнээр тасаллаа. Б.Дэлгэрсайхан гишүүн үг хэлье.

Б.Дэлгэрсайхан: Энэ Дотоодын цэргийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг зарчмын хувьд дэмжиж байгаа.

Одоо энд ингээд нэгэнт өөрчлөлт хийж байгаа юм чинь жоохон олигтойхон өөрчлөлт хийвэл яасан юм бэ гэсэн ийм санал байгаа юм. Манай гишүүд өнөөдөр нөхцөл байдлыг мэдэж байгаа. Ер нь дэлхий нийтээрээ бүх л оронд энэ цар тахлын дараах хямрал, дайн самуун гээд л ингээд ер нь бараг жагсаал цуглаангүй улс орон бараг байхгүй болсон.

Тэгээд одоо манай дотоодын цэрэг бол яг үнэндээ нөгөө нохойд барьдаг мод гэдэг шиг ингээд энэ гудамжинд байгаа бүх л муу муухай, бүх юмтай нүүр тулдаг.

Тэгээд энэ улсуудын тэр цалин хангамж, бас энэ нэг автобусны нэг жижигхэн юм яриад байх юм. Уг нь ийм яаралтай үед, гэнэтийн юм гарах үед энэ дээр төсөв нь ямар байх юм, үүнийг нь яаж шийдэх юм. Тэгээд нэг мөр энэ хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулаад ингээд шийдвэл яасан юм бэ гэдэг ийм санал байгаа юм. Хууль санаачлагчдад хэлэхэд.

Тэгэхгүй бол одоо ер нь цаашдаа ямар юм гарахыг хэн ч тааж мэдэхгүй болсон шүү.

Тэгээд одоо бид өнгөрснөө бол ингээд мартчихдаг. 7 сарын 01-ний 5 хүний амь нас гээд л ингээд л тэгээд ингээд ял үүрэх болохоор дотоодын цэрэг тэр командлагч, янз бүрийн улсууд нь ингээд ялаа үүрээд явчихдаг. Тэгээд эрх эдлэх юм байхгүй, зардал мөнгө байхгүй. Тэгээд нэг бензиний мөнгө гуйсан. Тэгээд бас нэг хувцасны мөнгө гуйсан нэг ийм л юм болж хувирч байгаа юм.

Энэ бол аль ч улс оронд одоо бол энэ гаднын дайн самуун гэхээсээ илүү дотоодын энэ нэг самуун бол бүх улс оронд бүр хэрээс хэтэрсэн. Бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээд энэ дээрээ яаж хандах юм бэ?

Одоо нэгэнт л энэ хуульд өөрчлөлт оруулах гэж байгаа юм бол энэ зардал мөнгө, энэ цалин, хангамж, тэгээд цаашдаа энэ орон тоо нэмэх, энэ бие даасан байдлыг нь яаж хангах энэ тэр гээд нэг мөр өөрчлөлт хийвэл яасан юм бэ гэдэг ийм санал байгаа юм. Үүнийг манай хууль санаачлагч нар бодож үзээрэй.

Одоо хэлэлцэх эсэхийг нь одоо хэлэлцэж байгаа гэж ойлгож байгаа. Яг орж ирэхэд нь одоо бас энд ямар нэмэлт, өөрчлөлт оруулах нь зөв юм гэдгийг бас бодож оруулж ирэх нь зөв байх. Тэгэхгүй бол нөхцөл байдал одоо энэ хавраас ямар болохыг хэн ч тааж мэдэхгүй.

Ер нь тийм сайн байна гэж одоо мэдэхгүй л байгаа шүү. Тэрийг бас бодолцоорой гэдгийг албан ёсоор хэлье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Б.Дэлгэрсайхан гишүүний хэлж байгаа саналуудыг хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг ирэх долоо хоногийн дөрөв дэх өдрийн хуралдаанаар шийдэгдэнэ. Түүний дараа ажлын хэсэг байгуулагдана. Тэр үед Б.Дэлгэрсайхан гишүүн бас хуулийн байгууллагад ажиллаж байсан туршлагатай хүний хувьд ажлын хэсэгт бас оролцоод саяын саналуудаа тусгаад явах боломжтой гэдгийг хэлье.

Ц.Сандаг-Очир гишүүн үг хэлье.

Ц.Сандаг-Очир: Би ч гэсэн бас санал нэгтэй байна. Улс орнуудад гарч байгаа нөхцөл байдлууд дотоодын дандаа үймээн самуун байнга гарч байдаг. Тэгээд нийгмийн дэг журмыг алдагдуулахгүй байх, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба хаагчдын нийгмийн асуудал, тэнд ашиглагдаж байгаа техник хэрэгслийн асуудал, тэнд тогтвортой ажиллах баталгааны асуудлууд гээд олон асуудлууд сөхөгдөж байгаа. Тэгээд салбар салбарын хуулиар жижигхэн жижигхэн аргацаагаад явахаасаа илүүтэйгээр бүр цогц байдлаар нь дотоодын цэрэг, цагдаагийн алба хаагч нар гээд энэ сонсогч нар ч хүртэл.

Саяхан л хэд хоногийн өмнө талбай дээр жагсаж байгаа жагсагчдад хүч нэмэгдүүлэх байдлаар ингээд л сонсогч нарыг авчирч харагдсан, дотоодын цэргийнхнийг авчирч байгаа харагдсан. Хөхөө өвлийн хүйтнээр л ботинктой зогсож байх жишээтэй. Тэгээд ботинктой энэ цемент дээр хэдэн цаг зогсох вэ гэдэг асуудлаас эхлээд л тэгээд л одоо юм болгонд л цагдаагийн алба хаагчид. Амарч чаддаггүй. Хамаг амьтан шинэ жилээр баярлаж байхад хэн ажиллаж байх вэ. Цагдаа, эмнэлэг. Цагаан сараар хэн баярлаж байдаг вэ, хэн амарж байдаг вэ, хэн ажиллаж хийдэг вэ. Цагдаагийн албан хаагчид, эмч нар л ажиллаж байдаг.

Тийм учраас энэ алба хаагчдын нийгмийн асуудлыг цаашдаа цалин мөнгөний асуудлыг дорвитой. Харин сая Хууль зүйн сайд харин цагдаагийн албан хаагчдын цалинг бас тодорхой хэмжээнд өөрийн нөөц бололцоонд нэмэгдүүлэх шийдвэр гаргасан байна лээ.

Тэгээд ер нь цаашдаа дорвитойхон нэмэгдүүлэхгүй бол цаашдаа төрийн тусгай албанд чинь ажиллах хүн ер нь олдохгүй болох шинжтэй юм билээ дээ.

Тийм учраас нэг салбарын хуулиар бага бага ингээд нэмэгдэл гэхээсээ илүүтэйгээр ер нь нийт хэмжээнд нь олигтойхон нэмэгдүүлэх, техник хэрэгслээр хангах асуудлуудаа цогцоор нь авч шийдэхгүй бол ер нь цаг үе, нийгэм өөрчлөгдсөн.

Гарч байгаа үймээн самуунуудыг нөхцөл байдал, өдөөн турхиралт, ашиглагдаж байгаа тэр зэр зэвсэг, санаа сэдэл нь бүр нарийн болчихсон учраас түүнээс илүү байж л энэ нийгмийн дэг журмыг хамгаална уу гэхээс биш одоо байгаа техник хэрэгсэл, одоо байгаа хүн хүчтэйгээ, одоо байгаа нийгмийн баталгаатайгаа яривал үнэхээр эрсдэлтэй бүсэд л нөхдүүд ажиллаж байгаа л гэж ингэж ойлгож байна.

Тийм учраас цаашдаа энэ алба хаагчдын нийгмийн асуудлыг цогцоор нь авч үзэх, техник тоног төхөөрөмж, хэрэгслээр нийгмийн баталгааг нь хангах, цалин мөнгийг нь урамшууллыг нь нэмэгдүүлэх гээд олон асуудлуудыг цогцоор нь авч үзэх ёстой юм билээ л гэж ингэж хэлье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Д.Цогтбаатар гишүүн үг хэлье.

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Хуулийг зарчмын хувьд үзэл бодлынх нь хүрээнд дэмжиж байгаа. Тэгэхдээ энд хэдэн зүйл бас хэлмээр байна. Х.Нямбаатар сайд бас үүнийг анхаарч бодож үзээсэй гэж бодож байна.

Юу гэвэл ер нь мэдээж цагдаагийн байгууллага, дотоодын цэрэг, энэ хууль хүчний байгууллагуудаа бэхжүүлэлгүй яах вэ. Эрх зүйн хувьд энэ байгууллагын статус, энэ юмнуудыг нь илүү тодорхой болгож өгөлгүй яах вэ.

Нөгөө талаасаа гэхдээ Монгол Улсынхаа хүрээнд ярьж авч үзвэл Монгол Улсын хүч нь юунаасаа гардаг вэ гэхээр иргэдийнхээ эрх чөлөөнөөс гарч байгаа шүү.

Тэгэхээр энэ дээр төр өөрийгөө хүчтэй болгохын зэрэгцээгээр иргэдийнхээ бухимдлыг төрүүлэхгүй байх, сайн засаглалтай, тийм засаглалыг сайн байлгахын үүднээс иргэд нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг, төрийн аливаа хэтэрсэн хүчирхийллээс айлгүйгээр чөлөөтэй илэрхийлдэг байж чадах чинь Монгол Улсын XXI зууны Монгол Улсын гол хүч нь шүү. Монгол Улсын гол хүч төрийн хүчиндээ биш иргэдийн эрх чөлөө тэр хүчиндээ байгаа гэдгийг бид эрх зүйн үүднээс нь аягүй сайн анхаарч ажиллах ёстой гэж бодож байгаа юм.

Тийм учраас цаашдаа хууль хүчний байгууллагуудын өөрчлөлт, шинэчлэлийг хийхдээ ч гэсэн иргэдийнхээ эрх чөлөөг энэ байгууллагууд чинь харин хамгаалж байх ёстой байгууллага шүү гэдгийг аягүй их бодмоор байгаа юм.

Тэгэхгүй бол сүүлийн үед ингээд л яриа сонсож байхад гудамжны хөдөлгөөн, эд нар юу ярьж байгаа юм бэ. Энэ чинь Монголын иргэд Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлээд, амьдрал нь хэцүү бол гарч ирээд хэнийг ч шүүмжлээд хэлэх эрхтэй. Тэгж засаглалд оролцож байгаа юм. Энэ чинь засаглалд оролцож байгаа хэлбэр нь байхгүй юу. Хуулиар хамгаалагдсан.

Тэгэхээр үүнийгээ бид бодох ёстой гэж бодож байгаа юм. Яг энэ үүднээсээ би хууль санаачлагчдад нэг хүсэлт тавимаар байна. Юу гэвэл энэ хуулийнхаа хүрээнд дараа нь энэ хүний эрхийн сургалтыг бүр тогтмолжуулж жил болгон хийдэг байх ёстой. Яагаад гэвэл энэ хууль хяналтын байгууллагад ажиллаж байгаа, ялангуяа энэ хүчний байгууллагынхан бол нэгдүгээрт хүний эрх гэдэг чинь юу юм бэ. Би ямар эрх зүйн орчинд ажиллаж байгаа билээ. Би хэнийг. Даргыг биш. Энэ иргэдийн аюулгүй байдлаа хамгаалж байгаа гэдгээ энд ажиллаж байгаа хүмүүс ягштал сайн мэддэг байх ёстой.

Тэр үүднээс нь тэр сургалтыг хийж байгаа чинь харин хөтөлбөр энэ тэрийг нь боловсруулахад би туслаад гаднынхантай бас ярьж байгаад боломжийн сайхан хөтөлбөр гаргаж өгөөд ажиллаж болно шүү гэдгийг хэлмээр байгаа юм.

Тэгээд ингээд зарчмын хувьд бол би дэмжиж байгаа.

Л.Мөнхбаатар: Ш.Раднаасэд гишүүн үг хэлье.

Ш.Раднаасэд: Сүүлийн үед цэрэг, цагдаагийн байгууллага маш олон хүмүүс залуучууд ажлаас гарах өргөдөл өгч байна гэсэн. Энэ юу юм гэхээр цалин амьдрал ахуйд нь хүрэхгүй болсонтой холбоотой шүү дээ.

Тэгээд энэ үйлдлийг дагуулаад дотоодын цэрэг энэ цэргийн албан хаагчдынхаа цалин цалинг нэмэх, нэмэгдүүлэх юмыг нь цуг хийгээд явчхаж болохгүй юу. Одоо энэ байдал тасралтгүй явна. Тасралтгүй явна. Яагаад гэвэл авч байгаа хэдэн цалин нь амьдралд нь хүрэхгүй, сарынх нь цалингаар арав хоногийнх нь хоол нь болохоор чинь тэр чинь цаана нь гэр бүл байна, эхнэр хүүхэд байна. Тэр хүн чинь яаж амьдрах юм бэ. Тэгээд цаг нар байхгүй. Тушаалаар. Хоно гэвэл хононо. Өглөө хэдэд буу гэвэл бууна. Яг ир гэсэн цагт нь ирээд л яв гэсэн цагт нь яваад л ингэдэг.

Тийм өөрчлөлтөө тод хийгээд явахгүй бол болохгүй байх. Одоо энэ том төрийн өмчтэй компанийн аж ахуйн нэгжүүдийн ТУЗ-ийн гишүүд гээд л зүгээр ТУЗ-д сард нэг очиж хуралдсаны төлөө хэдэн зуун мянгаар нь урамшуулал аваад сууж байгаа шүү дээ.

Тэр хувьцаа эзэмшдэг Уул уурхайн яам, эсвэл хувьцаа эзэмшдэг Зам тээврийн яам нь ч гэдэг юм уу төлөөлөөд хийж байгаа ажлаа хариуцаж очсоныхоо төлөө төрөөс цалин авна. Дээрээс нь ТУЗ-д ажилласны, хуралд суусны гээд урамшуулал авна. Энэ хямгадах ёстой юмнуудыг нь хямгадаад өгөх ёстой газрууд нь ахиухан цалин цавгийг нь нэмээд явахгүй бол одоо энэ байдал чинь замаа алдлаа.

Нэг л өдөр энэ жагсаал л эргээд энэ хүчний байгууллагууд өөрсдөө нийлнэ шүү. Энэ бол аюултай шүү. Энэ чинь бас хүн шүү дээ. Ялгаагүй л усан нүдтэй, цусан зүрхтэй хүмүүс ажиллаж байгаа шүү дээ.

Бид тэрийг тэр болгон тэнд алба хааж байгаа энэ жагсаал цуглаанд ард иргэдийн өмнөөс гараад зогсож байгаа арван хэдэн цагаар ингээд гадаа зогсож байгаа энэ хүмүүс зовлонгоо тэр бүр ирж ярихгүй л байгаа болохоос. Зүгээр ойлгодог бол энэ гаднаас нь харахад ойлгомжтой л байна шүү дээ.

Тэгээд энэ асуудлаа энэ дотоодын цэргийн хуультай цуг хийгээд явчихвал яадаг юм. Мэдээж дотоодын цэрэг, цагдаа хоёрын хангамж юу бол яг

ижил л явж байгаа. Энэ дээр нэг өөрчлөлтийг нь хийвэл хийгээд ингээд явахгүй бол одоо төсвийн хууль хараад л ингээд.

Тэгээд энэ боломжтой орлого зарлага олдог бол энэ сайд, дэд сайдууд дээр нь эрхүүдийг нь өгөөд тэр нэмэх ёстой нийгмийн халамж, анхаарлын бодлогуудын давхар явуулж л байя л даа.

Тэгээд ингээд бие биеэсээ ингээд бүр хамааруулаад уяад ингээд зангидаад гогцоог нь Их Хурал дээр татаад суучихаар чинь бүх юм чинь хөдлөх боломжгүй шүү дээ. Заавал Их Хурал руу нэг хууль оруулж ирж явдаг. Энэ байдлаа засахгүй бол бид одоо ингээд өнгөрсөн 30 жил ингэж явсан. Дахиад 30, 40 жил ч ингэж явна.

Тэгээд энэ байгууллагууд дээр ажиллаж байгаа дарга нарын чадавх чансаа, ялангуяа энэ аж ахуйн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж байгааг төрийн өмчит компаниудын чадавхаас чинь хамаарч өнөөдрийн нөхцөл байдал үүсэж байгаа шүү дээ. Ямар ч аж ахуй мэдэхгүй хүмүүс аваачиж тавиад. Тэр нь зүгээр хулгай хийхийн төлөө ажиллачихсан.

Наана нь тэд нарыг нь хамгаалаад энэ тэр цэрэг, цагдаа нь гараад зогсдог. Эд нарынх нь авч байгаа цалин амьдрал ахуйд нь хүрдэггүй. Энэ байдлуудаа засъя л даа одоо хэдүүлээ. Яах ёстой юм, одоо. Яг үнэндээ цагдаа бол дотоодын цэргийн бие бүрэлдэхүүний цалинг нэмэхэд хэн дургүйцэх юм бэ. Тэр дээр.

Энэ эмнэлгийнхэн байна. Одоо тэр хавдрын эмнэлгийн та нар очоод хар л даа. Нэг өдөр. Тэр дотор хүн явах зай байна уу. Хүн эмчлэх нь битгий хэл. Бүх эмнэлгийн байгууллагуудын санхүүжилт тасарч байна шүү дээ. Одоо.

Одоо үнэнээсээ тэрийгээ хийж чадахгүй учраас гэрээсээ ийм эм аваад ир. Үүнийг олоод ир. Үүнийг хийнэ гээд. Ийм л орчинд бид оччихсон байна шүү дээ. Энэ эрүүл мэндийн даатгал гэдэг чинь яг хэзээд нь өгөх ёстой юм. Түрүүлж өгөх ёстой юм уу. Одоо нь тэрийгээ мөнгө байхгүй учраас одоо аваад ир гэдэг. Ийм л нөхцөл байдал бүх газар очсон байна. Энэ сум, аймаг одоо бүгдийг нь нэг судлаад үзэх юм бол.

Энэ салбар салбар дээр байгаа зовлонгоо нимгэлье л дээ. Энэ сайд нарыг.

Л.Мөнхбаатар: Ш.Раднаасэд гишүүний хэлсэн тодорхой саналууд байгаа.

Эдгээрийг хуулийн төслийг хэлэлцэх эсэхээ шийдсэний дараа ажлын хэсэг гарч байгуулагдаж ажиллана. Энэ үедээ дотоодын цэргийн албан хаагчдын хууль зүйн баталгаа, аюулгүй байдлынх нь баталгаа, дээр нь эдийн

засгийн баталгаа, тэгээд цалин хангамжтай холбоотой энэ асуудлуудыг нэлээн нухацтай олон талаас нь ярих шаардлага байгаа гэдгийг хэлье.

Одоо Х.Нямбаатар гишүүн үг хэлнэ.

Х.Нямбаатар: Баярлалаа. Өнөөдөр Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг гишүүд маань дэмжлээ.

Сая би Ш.Раднаасэд гишүүний хэлсэн дээр нэмээд хэлэхэд сая Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар цагдаа, дотоодын цэргийн байгууллагын цалин хөлсний нэмэгдлийн асуудал шийдэгдсэн. Бусад хууль сахиулах байгууллагуудтай. Ер нь нэлээн ойртуулж шийдсэн. Энэ дээр цагдаа, дотоодын цэрэг гэж ялгалгүйгээр яг адилхан байдлаар нэмэгдээд байгаа.

Зүгээр ер нь сая энэ 2022 оны 3 дугаар улиралд цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас чөлөөлөгдөх хүсэлтэй бас нэлээдгүй хүмүүсийн өргөдөл, гомдлууд ирсэн байсан. Тэгээд бид бас цагдаа, дотоодын цэргийн байгууллагын цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг дэмжих чиглэлээр хэд хэдэн арга хэмжээнүүд авсны үр дүнд нөгөө ажлаас гарах хүсэлтээ өгсөн хүмүүсийн бараг дийлэнх нь буцаад эргээд албандаа ажиллахаа илэрхийлээд ингээд явж байгаа гэдгийг бас би мэдээллийг хэлэх ёстой.

Хоёр дахь зүйл бол Д.Цогтбаатар гишүүн их чухал асуудал хөндсөн. Энэ нөгөө хууль сахиулагчид, хүний эрхийн чиглэлийн сургалт, мөн албаны чиглэлийн сургалтуудыг явуулах тал дээр та бүхэн ер нь анхаарч ажиллах ёстой шүү гээд.

Тэгээд бид Д.Цолмон дарга, Л.Нямдаваа дарга Цагдаагийн байгууллагын тухай хуульд бас жижиг нэмэлт, өөрчлөлтүүд оруулахаар бэлдэж байгаа. Тэр нь юу вэ гэхээр бид энэ нөгөө law enforcement хүн ямар байх ёстой юм. Бид энэ чиглэлийн сургалтыг ямар чиглэлтэй явуулах вэ гээд Цагдаагийн байгууллагын тухай хууль дээр яг сургалт гээд тусад нь бүлэг бичиж байгаа юм.

Энэ сургалт нь нэг талаасаа хүний эрхийг хангах, нөгөө талаасаа давтан сургалтууд.

Тэгээд бид сая Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хэд хэдэн муж улсуудтай очиж ажиллаад хамтран ажиллах санамж бичгүүд зурсан. Тэгээд бид ер нь цаашид энэ хууль сахиулагчийн чиглэлийн сургалтуудыг өөрийн дотооддоо болон нөгөө хамтран ажиллах гэрээтэй улс орнуудад давтан сургалтуудыг зохион байгуулах чиглэлээр хэдэн ажлууд хийх гэж байгаа.

Зүгээр би өнөөдөр бас дэлгэрэнгүй юм ярихад юутай л байна. Жишээлэхэд, он гараад манай хил хамгаалах байгууллагын албан хаагчид мөн Европын холбоонд бид яг энэ хилийн цэрэг гэдэг бол хууль сахиулагчид юм

гэдэг тэр чиглэл рүү бид шилжилт хийх бас тодорхой сургалтын хөтөлбөрүүдийг тохироод эхнээсээ явж эхлэх гэж байгаа.

Хоёрдугаарт, цагдаагийн байгууллагын алба хаагчид, мөрдөх байгууллагын алба хаагчид бас мөнгө угаах, террозимтэй тэмцэх чиглэлээр бас сургалтуудад он гараад явж эхлэх гэж байгаа.

Тэгэхээр бид энэ эрх зүйн үндсийг нь Цагдаагийн байгууллагын тухай хууль дээр бүр аягүй тодорхой бичиж өгөх гэж байгаа юм. Энэ талдаа хүний эрхийг хангах, энэ талдаа албаны чиг үүргээ хууль тогтоомжид заасан хүрээнд хэрэгжүүлэх сургалт гэдэг ийм чиглэлийг оруулж ирнэ. 2023 он бол ер нь цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хувьд дандаа сургалт. Эрх зүйн үндэс нь ч бүрдэнэ. Өөрсдөө практик тал дээрээ ч явах ёстой юм байна лээ гэдэг энэ агуулгаар явж байгаа.

Дотооддоо дотоод хэргийн сургууль дээр бид бас давтан сургалтынхаа агуулгыг өөрчилье гээд агуулга, стандарт дээр өөрчлөлт оруулаад явж байгаа гэдгийг бас нэмж хэлье.

Л.Мөнхбаатар: Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулъя. Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 70.0 хувь нь дэмжсэн байна. Мөн Б.Дэлгэрсайхан гишүүн. Б.Дэлгэрсайхан гишүүнийг протоколд тэмдэглээрэй. Дэмжсэн санал өгсөн байна.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 70.0 хувь нь дэмжсэн.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулж дуусгалаа. /алх цохив/

Хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэн танилцуулах вэ? Б.Дэлгэрсайхан гишүүн танилцуулчихъя.

Дараагийн асуудалд орьё. Ажлын хэсэгт баярлалаа.

Гурав.Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан танилцуулна. Э.Бат-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Э.Бат-Амгалан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Шүүх шинжилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийн зарим хэсэг, заалтыг гүйцээн боловсруулах, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулж чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хувилбарыг бэлтгэлээ.

Шүүх шинжилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн ахлагч Э.Бат-Амгалан гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Н.Жамъянхүү, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, цагдаагийн хурандаа Ж.Буянбат, Шүүх шинжилгээний дүн бүртгэл мэдээллийн газрын захирал, цагдаагийн хурандаа Д.Мөнхбат, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний газрын Чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Б.Эрдэнэ-Очир, Шүүх шинжилгээний газрын Чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч А.Амгаланболд нар оролцож байна.

Дээр нь Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа Л.Нямдаваа оролцож байна.

Эцсийн хэлэлцүүлэг бэлтгэсэн талаарх төслийг гишүүдэд тараасан байгаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан эцсийн хэлэлцүүлэгт. Энэ чинь үг байхгүй билүү. Энэ чинь эцсийн хэлэлцүүлэг учраас үг байхгүй. Тийм ээ.

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан танилцуулна.

Дараагийн асуудалд оръё.

Дөрөв.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.03.11-ний өдөр өргөн мэдүүлсэн Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан танилцуулна.

Э.Бат-Амгалан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Шүүх шинжилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2022 оны 12 дугаар

сарын 01-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Шүүх шинжилгээний байгууллага нь лабораторийн тоног төхөөрөмж, шинжилгээний урвалж бодис худалдан авахдаа хуульд заасны дагуу тендер зарладаг бөгөөд тухайн урвалж бодисын хэмжээ, тээвэрлэлтийн онцлог, үйлдвэрлэлтийн явц зэргээс шалтгаалан тендер шалгаруулалтад хуулийн этгээдүүд оролцдоггүй. Үүнтэй холбоотой шинжилгээний явц удааширдаг, шинжилгээ тасардаг гэх мэт сөрөг үр дагавар гарсаар байна.

Ажлын хэсгээс хуулийн төслийн 55 дугаар зүйл 55.1.3 шинжилгээний байгууллага шүүх шинжилгээний үйл ажиллагааг шуурхай, тасралтгүй, үр дүнтэй явуулах хүрээнд шинжилгээний байгууллагыг шинжилгээний лабораторийн техник, тоног төхөөрөмж, программ хангамж, урвалж бодисоор шуурхай хангах, урвалж, бодисын нөөцийг бүрдүүлэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу шууд худалдан авах ажлыг зохион байгуулах зарчмын зөрүүтэй санал гаргасныг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Иймд хууль хоорондын зөрчил үүсэхгүй байх зорилгоор Төрийн болон Төрийн орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлд Шүүх шинжилгээний байгууллагын шинжилгээний лабораторийн техник, тоног төхөөрөмж, программ хангамж, мэдээллийг нууцлагч, техник хэрэгсэл, урвалж бодис худалдан авахдаа шууд гэрээ байгуулах тусгай заалтыг тусгалаа.

Түүнчлэн хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдээр хийлгэж болох шинжилгээний жагсаалтыг шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт тусгай мэдлэг бүхий хүнд шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгох, санал, дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус зөвлөл, цаашид зөвлөл гэх ажиллана.

Зөвлөлийн саналыг үндэслэн шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Шүүх шинжилгээний төв байгууллагын даргын шийдвэрээр 5 жилийн хугацаагаар олгоно гэсэн зохицуулалт дэмжигдсэнтэй холбоотой Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах шаардлага үүссэн.

Тодруулбал, Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсад зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны жагсаалт, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг энэ хуулиар зохицуулна гэж заасан учраас Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар доор дурдсан үйл ажиллагааг энгийн

зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно гэсэн хэсэгт шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг шүүх шинжилгээний байгууллага олгох зохицуулалтыг тусгаж хуулийн төслийг боловсрууллаа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Л.Мөнхбаатар: Э.Бат-Амгалан гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнууд өмнөх ажлын хэсэг хэвээрээ байгаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Д.Ганбат гишүүнээр тасаллаа. Ш.Раднаасэд гишүүн асуултаа асууя.

Ш.Раднаасэд: Танайх ер нь жилд хэд орчим төгрөгийн худалдан авалт хийдэг юм?

Тэртээ тэргүй наадах чинь хүн ордоггүй юм бол шууд худалдан авалт хийгээд ч хүн орох юм уу? Тендер зарлаад хүн ордоггүй, аж ахуйн нэгж ордоггүй гэж.

Энэ тендерээ зохион байгуулахдаа та нар өөрсдөө алдаа гаргаад байдаг юм биш үү. Одоо энэ эм, энэ хүн мэдэгдэхгүй худалдан авалтууд их байгаа шүү дээ. Энэ малын вакцин. Одоо ингээд та нарын урвалж бодис, өшөө юу юу байгаа бол.

Ингээд үүнийг энэ худалдан авах ил тод байдлаас гаргаад байхаар одоо нөгөө өрсөлдөөд байдал байхгүй болохоор наадах чинь ингээд л бас л нэг хулгай хийх үүр уурхай нэгдэж байгаа шүү дээ. Тэгээд өмнө нь яаж яваад байдаг байсан юм. Яг ийм ийм учраас бид техник, ийм ийм асуудал үүсээд ингэсэн гэдэг тэр юмыг чинь сонсмоор байна.

Жилд ойролцоогоор хэд орчим. Өмнөх дарга нар чинь энэ асуудлыг тэгвэл яагаад тавьдаггүй байсан юм? Эсвэл сүүлийн үед ийм болчхоод байгаа юм уу?

Хоёрдугаарт, жилд хэд орчим төгрөгийн ажил, үйлчилгээ худалдаж авдаг юм? Наад дотор чинь одоо бараг танай байгууллагатай холбоотой ширээ сандал бүх юм л орчих шиг боллоо.

Одоо энэ химийн хүрээлэн, Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүд хүртэл худалдан авалтыг нээлттэй хийж л байгаа шүү дээ. Ялгаагүй л урвалж бодисууд байгаа биз дээ. Үүнийг мэдмээр байх юм.

Тэгээд ер нь цаашдаа энэ жоохон нээлттэй энэ төсвийн хөрөнгө, энэ төсөвтэй холбоотой худалдан авах ажиллагаатай холбоотой тендер сонгон шалгаруулалттай холбоотой юмнуудаа жоохон нээлттэй болох чиглэлийг ер нь бид бүхэлдээ баривал яадаг юм бэ? Аль болохоор өөрийгөө хаах.

Тэр зайлшгүй юмнуудаар Худалдан авах ажиллагааны хуульд бол байгаа. Мэдээж батлан хамгаалахтай холбоотой, төрийн нууцтай холбоотой юмнууд байх нь гарцаагүй.

Хоёрдугаарт, тэр патент, зохиогчийн эрхтэй холбоотой дангаараа эзэмшиж байгаа тэр зүйлийг худалдан авалтад оруулах боломжгүй. Тэр бол ойлгомжтой. Дэлхийн чиг. Бид нарын энэ procurement-ын хууль гэж энэ Худалдан авах ажиллагааны хуулийг чинь 2015 онд шинэчилсэн үү. 2017 онд шинэчилсэн үү. Шинэчлэхэд ерөөсөө л амин сүнс нь үүнийг бүгдийг нь ил болгоё, нээлттэй болгоё гэж явсан шүү дээ. Одоо ингээд жижигхэн жижигхэн нүхлээд л нүх гаргаад байгаа байхгүй юу.

Энэ хуулийг чинь тойроод ингээд жаал хулгана үүрлэлээ шүү дээ. Одоо та нарын араас ямар байгууллага орж ирэх бол. Бүх байгууллагууд орж ирнэ. Нэг хэсэг нь ерөөсөө энэ хуульд хамаардаггүй худалдан авалт хийгдэж байна шүү дээ. Одоо энэ Авто тээврийн газар гээд. Өөрөө өөрийнхөө орлогыг өөрөө зарцуулаад явж байдаг. Энэ хууль руу ерөөсөө ордоггүй. Тэгээд Иргэний нисэхийн ерөнхий газар гээд. Бас л гадаадын дүрэм журмаар явдаг. Ингээд олон улсын конвенц гэрээтэй гээд.

Ийм саяын зүйлүүд дээр асуултад хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Ш.Раднаасэд гишүүний асуултад Ж.Буянбат дарга хариулъя. 6 номерын микрофоныг өгье. Ажил албаны онцлогууд байгаа бол тэрийгээ дурдаад хариулт хий дээ. Ажлын хэсгийн 6 номер.

Ж.Буянбат: Ш.Раднаасэд гишүүний асуултад хариулъя.

Энэ шүүх шинжилгээний байгууллага жилдээ 400-аас 500 сая орчим төгрөгийн эм, урвалж бодис авдаг. Энэ байнга шинжилгээ хийхэд өдөр тутам хэрэглэгддэг урвалж бодисууд сүүлийн хэдэн жил байнга тасалдалтай, худалдаж авч чаддаггүй ийм асуудалтай байдаг.

Зөвхөн лабораторийн тоног төхөөрөмж, программ хангамж. Одоо энд жишээ нь 2008 онд худалдаж авсан галт зэвсгийн хошуу, хонгио харьцуулдаг, эсвэл гарын мөр харьцуулдаг программ хангамж аваад үүнээс хойш бид

үүнийгээ ашиглаж чадахгүй өнөөдөр хүртэл ямар нэгэн байдлаар шинэчилж чадахгүй, ашиглаж чадахгүй байдалтай байгаад байдаг. Ганцхан нийлүүлэгчтэй. Тэгээд өнөөдрийг хүртэл үүнийгээ бид монголчлоод ашиглаж явж байгаа ийм хүндрэлтэй байдлууд байгаа юм.

Тэгээд яах вэ, 400-аас 500 сая төгрөгт ДНК-ийн голчлон урвалж бодис, цомог бодисууд авч байна. Заримдаа бүрэн гүйцэд ирдэггүй. Цомог бодис гэхээрээ олон төрлийн бодис нийлж байж нэг шинжилгээ хийх жишээтэй. Тэгээд үргэлж тасалдаг. Дээрээс нь тоног төхөөрөмжийн хувьд сонирхогчийн нийтийн хэрэгцээнд байдаг тэр тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдэх боломжтой. Яг мэргэжлийн тоног төхөөрөмж бид энэ тендерээр худалдаж авах ийм боломж хаалттай байгаад байгаа юм.

Л.Мөнхбаатар: Ц.Сандаг-Очир гишүүн асуултаа асууя. Ш.Раднаасэд гишүүн тодруулж асууя.

Ш.Раднаасэд: Танай чадавхыг дэмжих нэг том төсөл явж байх ёстой. Тийм ээ. Танай байгууллагын чадавхыг дэмжих. Хэдэн сая долларын. Тэр тоног төхөөрөмжийн шинэчлэлтэй чинь холбоотой төсөл байна уу? Өөр төсөл яваад байна уу? Тэр чинь хэдэн сая долларын өртөгтэй төсөл билээ?

Л.Мөнхбаатар: Микрофонд хариулна. Ж.Буянбат дарга хариулья. 6 номерын микрофон.

Ж.Буянбат: Ш.Раднаасэд гишүүний асуултад хариулья.

Солонгосын КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар 7 сая долларын төсөл хэрэгжээд хоёр дахь жилдээ явж байгаа юма.

Энэ төслийн хүрээнд гурван төрлийн лабораторийн тоног төхөөрөмж, тэгээд орчныг нь өөрчлөх тийм ажил хийгдээд эхэлчихсэн байгаа. Энэ ирэх оны 3 дугаар сард эхний төслүүд нь дуусгахаар ийм байдалтай байгаа.

Л.Мөнхбаатар: Ц.Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Нөгөө гуя дагуулж хүзүү гэдэг шиг тэгээд хуулийг нь батлаад өгсөн чинь бас тэгээд дагуулаад худалдан авалт, техник тоног төхөөрөмжөө одоо шуудаар худалдан авах шаардлагатай байна гээд ингээд оруулаад ирэх юм.

Шүүх шинжилгээний байгууллагын шинжилгээний лабораторийн техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг одоо техник, тоног төхөөрөмжийг нийлүүлчих компани олдохгүй байна гэж үү. Үнэхээр тэр мэдээллийг нууцлагч техник хэрэгсэл, урвалж бодисыг нь бол одоо тэгдэг юм байгаа биз гэж бодоход энэ чинь өргөн хүрээтэй шүү дээ. Маш том хүүдий нь нээчихлээ шүү дээ.

Тэгээд танайтай холбоотой бүх л худалдан авалтуудыг үндсэндээ шуудаар тендер зарлах нь л дээ. Шууд гэрээ байгуулаад. Энэ чинь бүх л юмыг нээлттэй болгоё. Энэ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендерийн хууль чинь нээлттэй байлгая л гээд байгаа шүү дээ. Гэтэл одоо тэгээд дагуулаад ингээд шууд л нэг нөхөртэй л ашиг сонирхлын зөрчил үүсэх юм биш биз дээ. Нөгөө эрүүгийн хууль, авлига, албан тушаалын хууль чинь одоо чангарчихсан шүү дээ.

Тэгээд өөрсдөдөө бас ингээд л лай хурааж байгаа юм биш биз. Одоо маш том хүүдий хийгээд ингээд лабораторийн техник, тоног төхөөрөмж бол лабораторитой. Мэргэжлийн хяналтын газрууд эд нар бүгд л лабораторитой шүү дээ. Тэгээд бүгд л техник, тоног төхөөрөмжөө тендер зарлаад л худалдаж авдаг шүү дээ. Тэгээд танай дээр болохоор яагаад болохгүй болчихоод байгаа юм? Тэр урвалж бодисууд бол үнэхээр асуудалтай байдаг нь үнэн.

Тэгэхээр би бол лабораторийн техник, тоног төхөөрөмж гэдгийг нь хасчихмаар л байна шиг байна. Үнэхээр одоо тэр мэдээллийг нууцлагч техник хэрэгсэл, нууцлагч, урвалж бодис гэдгийг нь үнэхээр тэр авах гээд байгаа бол шууд худалдан авалтаар нь хийгээд.

Тэгээд сандал ширээ, одоо өөр юу байдаг юм. Техник хэрэгсэл, компьютероо хүртэл та нар жишээлбэл шууд худалдан авалтаар л хийх нь байна шүү дээ. Техник, тоног төхөөрөмж дотор чинь орно шүү дээ. Энэ дээр нэг хариулт өгөөч.

Л.Мөнхбаатар: Хэн хариулах вэ? Ж.Буянбат дарга хариулъя. 6 номерын микрофон өгье. Ажлын хэсгийн.

Ж.Буянбат: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Одоо энэ КОЙКА-гийн төслөөр лаборатори орж ирнэ. Дагасан тоног төхөөрөмжүүд тэр болгон байхгүй. Гүйцэд биш байгаа. Бид энэ тоног төхөөрөмжийг цаг тухайд нь яг мэргэжлийн түвшний тоног төхөөрөмжийг л худалдан авах тухай л ойлголт байгаа юм.

Ажлын хэсэг дээр бас яг ингэж яриад энэ лабораторийг ингэж бүр тодруулж оруулж ирсэн байгаа юм.

Тэгээд сая сайдын хэлснээр тэр тоног төхөөрөмж гэдгийг нь хасаад программ хангамж, урвалж бодис гээд явчихад бас болохгүй юм байхгүй байгаа юм.

Л.Мөнхбаатар: Чи одоо төслөө дэмжээд явах хэрэгтэй шүү дээ. Энэ чинь байгууллагын дарга байж.

Нэмэлтээр хэн хариулах юм? 4 номерын микрофон. Ажлын хэсэг.

Н.Жамъянхүү: Хууль зүй, дотоод хэргийн яам. Н.Жамъянхүү.

Ц.Сандаг-Очир гишүүний асуултад нэмэлтээр хариулья.

Шүүх шинжилгээний байгууллага. Бид Тендерийн хууль дээр бүх шүүх шинжилгээний байгууллагын техник хэрэгслийг өргөн хүрээгээр худалдан авахыг шууд худалдан авалтад оруулаагүй. Зөвхөн тодорхой шинжилгээ хийхтэй холбоотой лабораторийн техник, тоног төхөөрөмж, программ хангамж, мэдээллийн нууцлалтай техник хэрэгслэл, урвалж бодисыг зөвхөн шууд худалдан авалт хийхээр оруулж ирсэн.

Одоо өнөөдрийн хэрэгжиж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиараа хэдийгээр гаднын лабораторийн техник, тоног төхөөрөмж нийлүүлдэг үйлдвэрлэлүүдийн дистербьютер компани ч байдаг юм уу, энэ компанийг заавал Монгол Улсад нийлүүлэхийг шаарддаг. Гэтэл Монгол Улсын жишээ нь одоо яг энэ чиглэлийн тоног төхөөрөмжийг нийлүүлж байгаа компаниуд ийм дистербьютер ч байдаг юм уу, тусгай итгэмжилсэн ийм эрх байхгүй тохиолдолд энэ нийлүүлэгдэхгүй.

Тэгэхээр бид энэ хуулиараа заавал тодорхой хэмжээгээр гурван удаагийн ч байдаг юм уу, хоёр удаагийн тендерийг зарлах шаардлага болдог.

Тэгэхээр ингээд бүтэн жилийн хугацаанд хугацаа алдах, тэгээд урвалж бодис тасрах ч юм уу, нөгөө эвдэрсэн техник, тоног төхөөрөмжийг засах, сэлбэг хэрэгсэл байхгүй тохиолдлоос болоод нөгөө шүүхийн шинжилгээ хийх, шинжилгээ хийж дүгнэлт гаргах энэ процесс ажиллагаа удаашрах, нөгөө эрүүгийн болон иргэний, захиргааны, арбитрын хэрэг маргаан шуурхай, тасралтгүй үргэлжлэх энэ нөхцөл байдал алдагдахад хүрдэг.

Тэгэхээр бид өнөөдөр яг энэ хууль дээр ингэж тодорхой хэмжээгээр оруулж өгч байгаа. Энэ хуулийн төсөл дээр шууд худалдан авах гэрээнд оруулснаараа ил тод байдал ч байдаг юм уу, өрсөлдөөн хязгаарлах зүйл байхгүй. Хэдийгээр шууд худалдан авалт хийгдэж байгаа ч гэсэн ил тод байдал болон шилэн дансныхаа тухай хууль болон тендерийнхээ хуулиар нээлттэй, ил тод ингэж мэдээлэгдэх ёстой.

Хоёрдугаарт нь, худалдан авалт, шууд худалдан авалт хийгдэхдээ бас тодорхой хэмжээний харьцуулалтын аргыг хэрэглэдэг ийм байгаа.

Л.Мөнхбаатар: Асуулт тодорхой байна. Д.Ганбат гишүүгээ асуултаа асууя.

Д.Ганбат: Миний мэдэхийн тэр КОЙКА-гийн төсөл чинь нэлээн хэдэн жил болчхож байгаа байх аа. Хэдэн оноос эхэлж байна. Хэзээ дуусах юм бэ? 7 сая долларын. Харин тийм ээ.

Нөгөө талаар энэ программ хангамж, энэ урвалжууд, энэ тоног төхөөрөмжүүдээ хаанаас авч байна вэ? Үүнийг тэгээд мэргэжилтнүүд нь байгаа юу? Мэргэжилтнүүдээ хаана бэлдээд байна? Тийм.

Нөгөө талаар энэ аймгуудад танайх салбартай санагдаж байна? Салбаруудын чинь нөхцөл байдал ямар байгаа вэ? Тэд нар бас тоног төхөөрөмжөөр хангагдсан байгаа юу?

Гурав гурван хүн байдаг билүү? Одоо хэдэн хүн байгаа билээ? Яг хаанахын харьяа хаана нь ажиллаад байна?

Дараагийнх нь, энэ Оюу Толгой энэ тэр гээд л баахан шууд шууд юм хумаа гаргадаг ийм компаниуд байгаа л даа. Тэр дотор тэгээд янз бүрийн байдлаар янз бүрийн ашигт малтмал дайварт нь явуулж байна. Нөгөөдүүл чинь тэр хүдрээ боловсруулахдаа хилийн чанад боловсруулдаг гэж байгаа. Тэрийг дагалдаад ямар ямар юм гарч байна вэ гэдгийг тэрийг нь тогтоож чадаж байгаа юу? Танай байгууллага.

Нөгөө талаар одоо бас төрийн байгууллагуудыг яг аж ахуйн тооцоотой ажиллуулъя гээд байсан уу, юу гээд байлаа. Бас нэг тиймэрхүү юм яриад байсан байх аа. Сүүлийн үед.

Тэгж ажиллахаар танайх тэгж ажиллах боломжтой юу? Уг нь энэ шүүх шинжилгээний байгууллага бол бас иргэдэд жоохон нээлттэй ингэж ажиллаж болох бололцоотой гэж бодоод байна л даа. Одоо нийгэм бол өөр болсон. Хүмүүс янз бүрийн нотлох баримтыг гаргаж өгч барьдаг ийм болсон байгаа. Тэрүүгээрээ манай энэ хууль чинь нээлттэй байгаа юу? Танайх одоо тийм нууцлалтайгаар тэрийг нь янз бүрийн байдлаар миний гарын хээ мөн үү, биш үү. Миний гар хөлийн үсэг мөн үү, биш үү гээд зөндөө олон юм байна л даа.

Тэгээд манай удам судрын хүн мөн үү, биш үү гээд л. Энэ чинь одоо хөрөнгө мөнгөн дээр маргадаг болчихсон байна гэсэн ийм зүйлүүд гарч ирнэ. Үүнийг нь зарим улсууд бараг гадагшаа яваад хийлгээд байх шиг байна. Манай Монгол Улсад энэ боломжтой юу? Үүнийг шийдвэрлэж байгаа юу? Ямар байгаа вэ гэсэн ийм асуултуудыг асууя гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Х.Нямбаатар сайд эхэлж хариулаад, Ж.Буянбат дарга нэмж хариулна. Д.Ганбат гишүүн бас нэлээн тодорхой хэдэн асуултуудыг асуулаа.

Х.Нямбаатар: Д.Ганбат гишүүн ээ, Монгол Улсад мэргэжлийн хяналтын лаборатори, Гаалийн ерөнхий газрын нэгдсэн лаборатори, Геологийн төв лаборатори, шүүх шинжилгээний байгууллага гээд бүгд тус тусдаа чиг үүрэгтэй.

Тэгэхээр шүүх шинжилгээний байгууллага бол экспортын уул уурхайн бараа бүтээгдэхүүний сорьцод дүн шинжилгээ гаргадаггүй байгууллага. Оюу Толгойн одоо жишээлбэл тэр түүхий эдэд дүн шинжилгээ гаргадаг байгууллага бол Геологийн төв лаборатори, Гаалийн ерөнхий газрын лаборатори хоёрын харьцуулсан дунджаар нь тухайн түүхий эдэд агуулагдаж байгаа эрдсүүдийг шинжилж гааль түүнд нь татвар авдаг.

Тийм учраас үүнтэй ерөөсөө холих боломжгүй.

Хоёрдугаарт, шүүх шинжилгээний байгууллагын үндсэн чиг үүрэг, хуулиар хүлээсэн үүрэг бол эрүүгийн болон иргэний, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчийн тэр дүгнэлтийг гаргах ийм үндсэн чиг үүрэгтэй байгууллага. Тэр утгаараа Монгол Улсын 21 аймагт өөрийн гэсэн төвүүдтэй. Мөн сум дундын бас нэгжүүдтэй. Тухайлах юм бол Хархоринд, Өмнөговь аймгийн Ханбогдод шүүх шинжилгээний нэгжүүд ажилладаг.

Аймгийн төвүүдэд ажиллаж байгаа шүүх шинжилгээний байгууллагууд бол шүүх шинжилгээний тодорхой хэдэн дүгнэлтүүдийг гаргадаг.

Саяын таны асууж байгаа энэ ДНК-ийн шинжилгээг одоогоор бидний энэ хууль дээр 5 төвүүд дээр ДНК-ийн шинжилгээг хийдэг больё. Одоо бол зөвхөн Улаанбаатар хотод хийж байгаа.

Цаашаагаа бидний зорилт бол 2024 оноос эхлээд 21 аймагт ДНК-ийн шинжилгээг хийдэг больё. Гэр бүлийн тухай хуулийг өргөн барьж байгаатай холбогдуулаад Гэр бүлийн тухай хуульд гэрлэгсэд нөгөө цус ойртолтоос сэргийлэх зорилгоор хувийн мэдээллийг хадгалж хүн болгоны ДНК-гийн шинжилгээ хийж, төрөл садан биш гэдэг дүгнэлтийг үндэслэж байж гэрлэх тэр захиргааны шийдвэрийг гаргадаг болохоор бид бас төлөвлөөд ажиллаж байгаа.

Энэ удаагийн хуулийн ер нь онцлогийг би бас нэг товчхондоо базаад хэлэхэд шинжлэх ухааны нарийн тэр мэдлэг шаардсан энэ дүгнэлтүүдийг шүүх шинжилгээний байгууллага, улсын хэмжээнд 5 төвүүдээрээ дамжуулж хийдэг больё. Дийлэнх шинжилгээнүүдийг хотод авчирч хийхгүй байя гэдэг нэг ийм урагшаа алхаж байгаа юм.

Хоёрт нь, аймаг, орон нутгуудын эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч шүүх эмнэлгийн үзлэг, дүгнэлтүүдийг аймгийн эрүүл мэндийн нэгдсэн төвүүдэд тодорхой эмч нарт, их эмч нарт зөвшөөрөл, лиценз өгөх замаар хамтарч хийдэг больё. Төрийн байгууллагууд хамтарч дүгнэлтээ гаргадаг больё гэсэн ийм агуулгатай явж байгаа.

Дотоод хэргийн их сургууль дээр шинжлэн магадлахуйн сургуулиар өнөөдөр шинжээч нараа бэлдэж байгаа. Дотоод хэргийн сургууль дээр. Бид цаашид Энэтхэг болон Бүгд Найрамдах Солонгос Улс, Турк Улс, Оросын Холбооны Улс гэх мэт улс орнуудтай бас хамтран ажиллах гэрээтэй.

Бакалаврын болон төгсөлтийн дараах шатны сургалтыг эзэмшүүлэх чиглэлээр ажлууд эхлүүлчихсэн явж байгаа. Ойрын үед бид бас Энэтхэгийн Хууль зүйн сайдтай хамтарч Хууль зүй, дотоод хэргийн яам хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Энэтхэгийн шинжлэн магадлахуйн сургуульд бид бас хүмүүсээ давтан сургах чиглэлээр тодорхой ажлуудыг ахиц дэвшил гаргахаар, сургахаар үндсэн тохиролцоонд хүрээд ажиллаж байгаа.

Яг одоо хаанаас юу юу авч байгаагаа Ж.Буянбат захирал хэлэлцчих.

Л.Мөнхбаатар: Х.Нямбаатар сайд нэлээн хэдэн асуултад нь хариулчихсан байгаа.

Д.Ганбат гишүүн бол Хууль зүйн байгууллагын дарга байх үед энэ төсөл эхэлсэн. Нэлээн урт хугацаанд хэрэгжиж яваад одоо бол энэ төслийнхөө явц, дүнгийн талаар бас тодруулаад хариулаарай. Ж.Буянбат дарга. 6 номерын микрофон.

Ж.Буянбат: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Энэ КОЙКА-тай хамтарч хэрэгжүүлж байгаа төсөл маань 2014 онд эхний яриа хэлэлцээр нь хийгдэж эхэлсэн юм билээ. Их олон талаасаа юу судлаад 2018 оноос яг албан ёсоор хэрэгжсэн.

Яг өнөөдрийн байдлаар хими, биологи, тэгээд бичиг судлал, дээрээс нь дижитал буюу тоон технологийн шинжилгээ хийх лабораториудыг шинэчилж байгаа. Боловсон хүчнийг нь 21-ээс 45 хоногийн сургалтад Солонгос Улсад хамруулж байгаа.

Тэгэхээр энэ лаборатори дээрээ боловсон хүчин маань ажиллаж чадна гэсэн ийм сургалтад хамрагдаад ирж байгаа юм.

21 аймагт албатай, 8 сум дундын хэсэг ажилладаг. Энэ хууль батлагдсанаар цаашдаа бид эхний ээлжид 5 бүсийн шинжилгээний газрууд бий болж, тэнд ДНК, хими, биологи гээд ингээд нарийн шинжилгээнүүдийг хийдэг болохоор бүх шинжилгээнүүдийг Улаанбаатар хотод биш 5 бүсчилсэн төвүүд дээрээ хийдэг болохоор ийм зорилттой ажиллаж байгаа юм. Танилцуулж дууслаа.

Л.Мөнхбаатар: Нэг зүйлийг тодруулж асууж байна. Хувь хүмүүсийн шинжилгээ хийх боломжтой юу? Түүнийг хэрхэн хүлээн зөвшөөрөх боломжтой талаар нэмээд хариулчих. 6 номерын микрофон.

Ж.Буянбат: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Ер нь шинжилгээ заавал шинжээч томилох эрх бүхий субъектын томилсон шийдвэрийг үндэслэж хийнэ. Одоо энэ хуулийн төсөлд маань

шинжилгээний байгууллага хийх шинжилгээ, гадуур хийлгэх шинжилгээ гээд бас аль алиныг нь зохицуулж өгсөн байгаа.

Хэрвээ яг энэ хуульд тавигдсан шаардлагыг хангасан, тэгээд шинжээчийн эрх авсан хүн бол гадуур шинжилгээ хийх боломжтой болж байгаа гэсэн үг.

Л.Мөнхбаатар: Д.Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Ингээд бид чинь одоо бас ингээд цус ойртох гэдэг асуудал бол нэлээн тийм гамшгийн байдалд орж байна гэсэн ийм судлаачид яриад байгаа.

Тэгээд тэр гэр бүлийн хуульдаа ч гэсэн оруулах юм байна гэж ойлгоод байна.

Гэхдээ тэрийг одоо бас яг тэгж хуульчилж энэ тэр шинжлэх ёстой юу? Ямар байх вэ? Зүгээр сайн дурын үндсэн дээр байх уу? Энэ дээр чинь одоо хүний эрх зөрчигдөх үү? Ямар байна? Одоо дунд сургуульд чинь нөгөө юу хийхээ больчихсон байх. Тийм ээ. Охидуудын үзлэг энэ тэр гэж хийхээ больчихсон байх. Хуучин бол тийм л байсан шүү дээ. Социализмын үед. Тийм ээ. Аан. Тэр нь тухайн үедээ хэрэгтэй ч байсан байх. Одоо бол хүний эрх гэж яриад үүнийгээ бас арай өөрчилсөн байх.

Манай Ардын намынхны үед энэ асуудлыг одоо яаж шийдэж байна? Тийм. Үүнийг бас нэг сонирхоодохъё.

Л.Мөнхбаатар: Д.Ганбат гишүүний асуулт бол Х.Нямбаатар сайдад хаяглагдсан асуулт байх шиг байна гэж бодоод байна. Энэ бол ДНК-ийн шинжилгээ хийхтэй холбоотой.

Х.Нямбаатар сайд өмнө нь нэг ярилцлагадаа хэлсэн. Түүнтэй холбоотой асуугаад байна гэж ойлгож байна. Х.Нямбаатар сайд хариулчихья. Гэр бүлийн хуульд ийм өөрчлөлт оруулах гэж байгаа юу л гэдэг агуулгаар асууж байна шүү дээ. Х.Нямбаатар сайд асуултад хариулъя.

Х.Нямбаатар: Гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсрогдоод дуусаж байгаа. Одоо энэ долоо хоног, ирэх долоо хоногт хэлэлцүүлгүүд хийгдээд, тэгээд Их Хуралд өргөн барихаар төлөвлөж байгаа.

Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо ажлын хэсгийг ахалж байгаа. Бид 1973 оны гэр бүлийн хууль 1999 онд нэг шинэчлэгдсэн юм. 1998 онд.

Энэ гэр бүлийн хууль хоёр зорилтыг үндсэндээ нөгөө хууль хэрэгжилтийн үр нөлөөллийг үзэхэд жоохон дутуу дулимаг хангагджээ гэж үзэж байгаа юм. Нэг нь болохоор энэ саяын таны ярьдаг цус ойртолтыг бид сэргийлэх зорилгоор

1998 оны гэр бүлийн хуулиар ургийн овог, эцгийн нэр, нэр гээд ургийн овог хөтлөх, угийн бичиг хөтлөхийг хуульчилж өгсөн юм.

Харамсалтай нь манайхан тухайн үед ургийн бичгээ хөтлөхдөө ерөөсөө хариуцлагатай хандаагүй. Бүгд шахуу боржигон гэдгээр явсан.

Тийм учраас бид шинэ гэр бүлийн хуулиар цус ойртолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор ДНК-ийн шинжилгээ.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ер нь шүүх шинжилгээний байгууллагын хувьд ажил албаны нэлээн онцлогтой байгууллага гэдгийг та бүгд маань мэднэ.

Ер нь анх цагдаад байсан криминалистикийн төв, шүүх эмнэлэг, мөн шүүх нягтлан бүртгэх бүртгэл гээд байгууллага Сангийн яаманд байсан. Энэ гурван байгууллага одоо нэгтгэгдээд Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн болж байгуулагдсан.

Гурвуулаа их амаргүй, их өөр өөрийн онцлогтой ийм байгууллагыг нэгтгээд одоо бол агентлаг болоод ингээд байгуулагдаж үйл ажиллагаа явуулахаар болж байна.

Энд сая энэ хуулийн төсөлтэй холбогдуулаад хэлэхэд төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах энэ хуулийн төсөл дээр манай гишүүд дэмжих нь зүйтэй болов уу гэж би бодоод байгаа юм.

Яагаад гэхээр энэ байгууллага дээр Хууль зүйн байгын хорооны ажлын хэсгүүд очиж ажилласан. Нөхцөл байдал үнэхээр хүнд байгаад байгаа юм. Энэ урвалж бодисуудын дутагдлаас болоод тодорхой шинжилгээнүүд хийгдэхгүй байдаг. Хийгдээгүйгээс болоод маш олон хэрэг маргаан, гомдол, саналтай иргэдийн асуудал гардаг.

Зарим урвалж бодисууд нь нэг литр ч гэдэг юм уу, 500 граммаар хүртэл ингээд захиалж зарладаг. Тэгээд үүнд нь орох орохгүй гээд асуудлууд үүсдэг. Одоо тодорхой төрлийн шинжилгээний бодисууд байна. Хар тамхи гээд тэгэх юм бол одоо Америкаас ч гэдэг юм уу, аль нэг улсаас шууд худалдан авахаас аргагүй байна. Зарим тоног төхөөрөмж дээр 2008 онд л анх хэрэгжиж эхэлсэн **PAPILLON systems** гээд хурууны хээ систем маань байж байна. Энэ системийг хөгжүүлээд явж байгаа. Гэтэл үүнтэй холбоотой зүйл нь нэг харилцагчдаа ч байдаг юм уу. Энэ мэтчилэн. Мөн буу сум, одоо галт зэвсэгтэй холбоотой гэх мэт ийм олон онцлогууд байгаад байгаа юм.

Тийм учраас лабораторийн шинжилгээ гэж байгаа болохоос биш бусад тоног төхөөрөмж буюу одоо компьютер, принтертэй адилтгаж үзэхээргүй ийм онцлог байгаа шүү гэдгийг гишүүддээ хэлье.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Горимын санал байгаа юу? Э.Бат-Амгалан гишүүн. Ажлын хэсгийн ахлагч горимын санал гаргая.

Э.Бат-Амгалан: Саяын хуулийн төслүүдтэй холбоотой гишүүдээс тодорхой санал гараагүй учраас дэгийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэж явуулж өгөх горимын санал гаргаж байна. Санал хураалгаж өгнө үү. Дарга.

Л.Мөнхбаатар: Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах Э.Бат-Амгалан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд ээ.

Хуралдаанд оролцсон гишүүд уг горимын саналыг 66.7 хувь нь дэмжсэн байна.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Горимын санал. Э.Бат-Амгалан гишүүн гаргая.

Э.Бат-Амгалан: Хуулийн төсөлтэй холбоотой гишүүдээс санал гараагүй учраас дэгийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн хэлэлцүүлж өгөхийг хүсэж горимын санал гаргаж байна.

Л.Мөнхбаатар: Э.Бат-Амгалан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд ээ.

Уг горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь дэмжсэн байна.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Энхтайваны Бат-Амгалан танилцуулна.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД